

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 5 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-21
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	22-63
<hr/>	
1. “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	22-23
2. “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	23-26
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	26-27
4. Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	27-63
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
5 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 48 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Зулпхар;

Чөлөөтэй: Ц.Баатархүү, Ш.Бямбасүрэн, М.Нарантуяа-Нара, Б.Түвшин.

Нэг. “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга П.Ганзориг “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Ганзориг: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5

Бүгд: 20

75.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн тавьсан асуултад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх П.Батчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 4
Бүгд: 21
81.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баярбаатар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргав.

П.Ганзориг: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	18
Татгалзсан:	4
Бүгд:	22

81.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын төрөлжсөн мэргэшлийн тусламж хариуцсан ахлах шинжээч М.Оюунчимэг, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Үйлдвэрлэлийн тасгийн технологич их эмч Н.Халиун, мөн төвийн Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга Э.Тунгалагтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Баясгалан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Цусны донорын тухай хуулийн төслийн талаар:

П.Ганзориг: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Б.Баярбаатар, Л.Энхнасан, Х.Болормаа, Д.Рэгдэл, У.Отгонбаяр, М.Сарнай, С.Эрдэнэбат /цаашид

“Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилгоор сайн дураар цусаа үнэ төлбөргүй өгөх болон цусны донорын үйл ажиллагаа, цусны аюулгүй байдал, бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр хариулж, тайлбар хийв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, Б.Бейсен нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилтын хүрээнд цусны донорын үйл ажиллагааг зохион байгуулах, цусны аюулгүй байдлыг хангах, цус сэлбэлт судлалын салбарын бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэнд, амийг аврах зорилгоор цус сэлбэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 5
Бүгд: 24
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “цус” гэснийг өмнө “цус, цусны бүрэлдэхүүн хэсэг” гэж, мөн заалтын “аюулгүй байдлыг хангахтай” гэснийг “аюулгүй байдал, сонор сэрэмжийн тогтолцоотой” гэж өөрчилж, мөн зүйлийн 3.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 5
Бүгд: 24
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.1.4 дэх заалт нэмэх:

“3.1.4.“цусны байнгын донор” гэж жилд тогтмол хоёр ба түүнээс дээш удаа цусаа өгсөн хүнийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 5
Бүгд: 24
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах зорилгоор” гэснийг, мөн зүйлийн 3.1.8 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 5
Бүгд: 24
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “биобэлдмэл” гэснийг “бэлдмэл” гэж, мөн заалтын “цус, цусны бүрэлдэхүүн хэсгээс” гэснийг “цусны сийвэнгээс” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 3.1.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 5
Бүгд: 24
79.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх:

“3.1.12.“цусны сонор сэрэмжийн тогтолцоо” гэж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг авах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх явцад гарах сөрөг урвал, хүндрэлийг илрүүлэх, шуурхай арга хэмжээ авах, сэргийлэх цогц үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 7

Бүгд: 24
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтыг хасах:

“4.1.3.чанар, аюулгүй байдлыг хангах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 8
Бүгд: 24
66.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хоёрдугаар бүлгийн нэрийн “ТОГТОЛЦОО” гэснийг “УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ” гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдал, цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай холбоотой төрийн хяналтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 8
Бүгд: 24
66.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “, цусны биобэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэх” гэснийг хасаж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 8
Бүгд: 24
66.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан хариулж, тайлбар хийв.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “төрийн бодлогыг Улсын Их Хурлаар батлуулах,” гэснийг “бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн” гэж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын

“санхүүжилтийг” гэснийг “түүнтэй холбогдон гарах санхүүжилтийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 8
Бүгд: 24
66.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “гамшгийн” гэсний дараа “болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хэмжээ” гэснийг “албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг” гэж өөрчилж, мөн заалтын “, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “үйл ажиллагааг зохицуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.2.цусны донорын үйл ажиллагааны талаар баримтлах бодлого боловсруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “батлах” гэснийг “баталж, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, мөн зүйлийн 8.1.5 дахь заалтын “орц, илчлэгийн жишиг” гэснийг “зардлын” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “нэмэгдэл цалингийн хэмжээ,” гэснийг “цалин, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл” гэж, мөн заалтын “санал боловсруулах” гэснийг “талаар санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг 8.1.7, 8.1.8 дахь заалт болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.7.цус сэлбэлт судлалын салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх;

8.1.8.цусны донорын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх болон өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэндийг дэмжих санд тусгах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дахь хэсэг нэмэх:

“8.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хуулийн 15.1.12-д” гэснийг “хуульд” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 10

Бүгд: 24

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтын “цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоог” гэснийг, мөн заалтын “удирдлага зохион байгуулалт,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 11

Бүгд: 24

54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын “сурталчилгааны ажлыг” гэснийг “сурталчилгаа, донорын эгнээг өргөжүүлэх ажлыг” гэж өөрчилж, мөн заалтын “, цусны донор элсүүлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 10

Бүгд: 24

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь заалтын “биобэлдмэл” гэснийг “бэлдмэл” гэж, мөн зүйлийн 9.3.7 дахь заалтын “талаарх магадалгаа” гэснийг “тухай тодорхойлолт” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.3.8 дахь заалтын “байгууллага,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 10

Бүгд: 24

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.9.энэ хуулийн 20.1-д заасан донорыг Засгийн газрын шагнал болон бусад шагналд нэр дэвшүүлэх саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 9

Бүгд: 24

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.3.10 дахь заалт нэмэх:

“9.3.10.цусны байнгын донорт тэмдэг олгох,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.10 дахь заалтын “бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх” гэснийг “аюулгүй байдлын талаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.3.11 дэх заалтын “улсын хэмжээнд нэгтгэх,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.4.Цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлд шаардагдах төсвийн зардлаа жил бүрийн улсын төсөвт тусгуулахаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.5.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь дараах байгууллагатай хамтран ажиллана:

- 9.5.1.эрүүл мэндийн байгууллага;
- 9.5.2.төрийн болон төрийн бус байгууллага;
- 9.5.3.аж ахуйн нэгж, байгууллага.

9.6.Хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаярын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр хариулж, тайлбар хийв.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.3, 15.1.5, 15.1.6, 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллага цусны донорын үйл ажиллагаанд оролцоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Энэ хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд цусны донорын үйл ажиллагаа, цусны чанар, аюулгүй байдлыг хангах, журам, стандарт, зааврыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “донор элсүүлэх” гэснийг хасаж, мөн заалтын “тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд” гэснийг “цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 9
Бүгд: 25
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.2.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, ажил олгогчийн эрх, үүрэг” гэснийг “Цусны донорын үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “байгууллагын албан тушаалтан ажил олгогч нь” гэснийг “болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж” гэж, мөн зүйлийн 12.1.3 дахь заалтын “магадалгааг” гэснийг “тодорхойлолтыг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 9
Бүгд: 25
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4 дэх заалт нэмэх:

“12.1.4.цусны донорын үйл ажиллагааны талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 11
Бүгд: 25
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, М.Ганхүлэг, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн

Ж.Баясгалан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн даатгал” гэснийг хасаж, “хамт олон, иргэн,” гэсний дараа “олон улсын байгууллагын” гэж нэмж, төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь өөрийн орлого, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдсэн санхүүжилтийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.5-д заасны дагуу зарцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 8
Бүгд: 25
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсгийг бүхэлд нь тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 8
Бүгд: 25
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.6.Цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 8
Бүгд: 25
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн “Цусны албаны нэмэгдэл цалингийн хэмжээг” гэснийг “Энэ хуулийн 13.6-д заасан нэмэгдэл олгох журмыг эрүүл мэндийн болон” гэж, мөн хэсгийн “тогтооно” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 8
Бүгд: 25
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хариулж, тайлбар хийв.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийн “СЭЛБҮҮЛЭГЧ,” гэснийг хасаж, төслийн 14, 17 дугаар зүйлийг нэгтгэн 14 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14 дүгээр зүйл.Цусны донорт тавигдах шаардлага, түүний эрх, үүрэг

14.1.Цусны донор дараах шаардлагыг хангасан байна:

14.1.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ сайн дураар, авлагагүйгээр өгөхийг зөвшөөрсөн байх;

14.1.2.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байх;

14.1.3.эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх.

14.2.Цусны донор дараах эрхтэй:

14.2.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөнтэй холбоотой гарч болзошгүй сөрөг урвалын талаар мэдээлэл, зөвлөгөө авах;

14.2.2.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх ажилд сайн дураар оролцох;

14.2.3.хуульд заасан бусад.

14.3.Цусны донор дараах үүрэгтэй:

14.3.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 18.2.7-д заасан мэдээллийг холбогдох эмнэлгийн мэргэжилтэнд үзүүлэх.

14.3.2.өөрийн эрүүл мэндийн байдлыг асуумжийн дагуу үнэн зөв мэдээлэх;

14.3.3.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгөхийн өмнөх үзлэг, шинжилгээнд хамрагдах;

14.3.4.эмнэлгийн мэргэжилтний өгсөн зөвлөмжийг мөрдөх;

14.3.5.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 8

Бүгд: 25

68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, П.Наранбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15, 16, 18 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

15.1.Иргэний амийг аврах, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэхдээ сэлбүүлэгч эрх зүйн бүрэн чадамжтай бол өөрөөс нь, хүүхэд болон эрх зүйн бүрэн чадамжгүй сэлбүүлэгчийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бичгээр зөвшөөрөл авсан байна.

15.2.Энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авахдаа цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх шаардлага, сэлбэх явцад гарах үр дагаврын талаар сэлбүүлэгчид урьдчилан танилцуулсан байна.

15.3.Амь тэнссэн үед, эсхүл энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авах боломжгүй тохиолдолд холбогдох журам, зааврыг баримтлан цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэнэ.

15.4.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

15.5.Хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	9
Бүгд:	25

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр нар хариулж, тайлбар хийв.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлийг нэгтгэн 19 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх

19.1.Монголын улаан загалмай нийгэмлэг болон төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага болон албан тушаалтан, иргэн нь цусны донорыг элсүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаанд сайн дурын ажилтныг оролцуулж болно.

19.4.Цусны донорыг “Цусны хүндэт донор” цол тэмдгээр дараах шалгуурын дагуу шагнаж, алдаршуулна:

19.4.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш өгсөн;

19.4.2.цусаа 35 болон түүнээс дээш өгсөн;

19.4.3.ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш өгсөн.

19.5.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

19.6.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

19.7.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд Засгийн газраас тогтоосон сувиллын жишиг үнийн дагуу жилд нэг удаа сувилуулна.

19.8.Энэ хуулийн 19.7-д заасан дэмжлэгийг Ахмад настны тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан дэмжлэгтэй давхардуулан олгохгүй.

19.9.Энэ хуулийн 19.7-д заасан дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа жишиг үнийн дагуу сувилуулах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.10.“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүндэт донор”, “Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүндэт донор” цол тэмдэгтэй иргэнд энэ хуулийн 19.7-д заасан дэмжлэг хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 11

Бүгд: 25

56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Тусламж, ажил үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга Э.Тунгалагтуяа хариулж, тайлбар хийв.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тээвэрлэх үйл ажиллагааг” гэсний дараа “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 15.1.12-т заасан” гэж нэмж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.12-т заасан эрүүл мэндийн байгууллага нь цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах зориулалтаар тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглан энэ хуулийн 22.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

22.3.нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүйгээр зорчих.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 11
Бүгд: 25
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “гүйцэтгэж болно.” гэснийг “гүйцэтгэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.4, 22.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 11
Бүгд: 25
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “зүйлийн 22.5 дахь хэсэгт заасан” гэснийг “хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн” гэж, мөн заалтын “цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан” гэсний дараах “тусгай мэргэжлийн төвд” гэснийг “эрүүл мэндийн байгууллагад” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 11
Бүгд: 25
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.7, 22.8 дахь хэсгийг нэгтгэн 22.7 дахь хэсэг болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.7.Цус, цусан бүтээгдэхүүнийг Эрүүл мэндийн тухай хуулийн 37.3-т заасан журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийн “биобэлдмэлийг” гэснийг “цусны бэлдмэлийг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “байдлын хувьд баталгаажсан” гэснийг “байдлыг хангасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 9
Бүгд: 25
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “онцгой” гэснийг “ноцтой” гэж өөрчилж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах ажлыг улсын хэмжээнд гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба, тодорхой нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед орон нутгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 9
Бүгд: 25
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.3, 24.4, 24.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 9
Бүгд: 25
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “24.1, 24.3, 24.5-д заасантай” гэснийг “24.1-д заасан зохион байгуулалттай” гэж, мөн хэсгийн “холбоотой зардлыг” гэсний дараах “Засгийн газрын нөөц сангаас” гэснийг “Гамшгийн тухай хуулийн 51.4-т заасны дагуу” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 9
Бүгд: 25
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийн “сангийн” гэснийг “сан байгуулах, ажиллах” гэж өөрчилж, мөн хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараах “асуудал эрхэлсэн” гэснийг хасах:

“25.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор цусны донорын мэдээллийн сантай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 11
Бүгд: 25
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.3, 25.4, 25.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 10
Бүгд: 25
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр хариулж, тайлбар хийв.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “, мэргэжлийн хяналтын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 9
Бүгд: 25
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн гарчгийн “Цусны донорын үйл ажиллагааны журмыг зөрчигчдөд” гэснийг “Хууль зөрчигчид” гэж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг “Төрийн албаны тухай” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 7
Бүгд: 25
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.1 дэх хэсэг нэмэх:

“28.1.Энэ хуулийн 6.1.6, 8.1.5, 9.4, 13.6-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлтэй холбоотой хэсэг, заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 7
Бүгд: 25
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 7
Бүгд: 25
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 7
Бүгд: 25
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 7
Бүгд: 25
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

П.Ганзориг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 7
Бүгд: 25
72.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 38 минут үргэлжилж, 30 гишүүнээс 25 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Ганзориг: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн ирсэн байна. Тэгээд гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 56,7 хувьтай бүрдсэн тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 5 сарын 5-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай, Аюушийн Ариунзаяа, Отгоншарын Батнайрамдал, Жанчивын Галбадрах, Пүрэвжавын Ганзориг, Даваасамбуугийн Ганмаа, Мөнгөнцогийн Ганхүлэг, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Дүгэрийн Рэгдэл, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Ганбатын Хосбаяр, Бадарчийн Хэрлэн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Лутаагийн Энхнасан, Доржзовдын Энхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд Байнгын хорооныхоо хуралдаанд хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Байнгын хорооны тогтоолын төсөл “Цаглавар батлах тухай”

2-т “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг байгаа.

3-д нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл мөн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг байгаа.

4-д Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг бас хэлэлцэнэ. Энэ бол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нарын 4 гишүүнээс 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг явагдана.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар байгаа.

Ингээд Цаглаварын Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Та бүхэнд бас тараагдсан байж байгаа.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 179 дүгээр захирамжид заасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2. Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3. Энэ тогтоолын төслийн биелэлтийг хангаж ажиллахыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо /П.Ганзориг/-нд, хэлэлцэх асуудлыг бэлтгэн хангах, мэргэжил арга зүйн зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т үүрэг болгосугай.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга гэсэн ийм тогтоолын төсөл.

Цаглаварыг дэлгэц рүү өгөх боломж байна уу. Харуулчих тэгэх үү. Шаардлагагүй юу. Тэгвэл тогтоолын төслийг та бүхэнд танилцууллаа. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Цаглавартай холбогдуулаад байхгүй байна. Асуулт, хариулт байхгүй. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Ингээд Байнгын хорооны гишүүд санал хураалтад бэлтгэе. Хосбаяр гишүүн санал хураалтынхаа бэлтгэлийг хангана уу. Мөнхтуяа гишүүн санал хураалтынхаа бэлтгэлийг хангана уу. Санал хураалтаа явуулъя.

“Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад нийт 20 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 75 хувиар дэмжигдлээ.

13.54 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Н.Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, М.Наранпүрэв Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, С.Жаргалсайхан Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Б.Алтантулга Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга, П.Батчулуун Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх. Төрийн нарийн бичгийн дарга нь орж ирээгүй байна уу.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Баярмагнай Баярбаатар гишүүн танилцуулна.

Б.Баярбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5, 42.8 дахь хэсэгт заасны дагуу “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрхтэн эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Ганзориг: Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байна уу. Энхнасан гишүүнээр тасаллаа. Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Өдрийн мэнд мэнд хүргэе. Би нэг л юмыг ажлын хэсэг дээр ч гэсэн асууж байсан. Энийгээ дахиад тодруулаад асуугаадахъя. Энэ хуулийн төслийн энэ 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлд бол Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгахыг хариуцсан байгууллага буюу тусгай мэргэжлийн төв байна гээд заасан байгаа. Тэгэхээр энэ бид нар бас Байнгын хороо дээрээ бас төсвийг баталж байхад эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн төсвийг бас баталсан. Тэгээд энэ улсын 1 дүгээр эмнэлгийн хашаанд бас баригдаж байгаа төв гэж би ойлгоод байгаа юм. Энэ 2 төв маань дараа нь 1 төв болох юм уу. Ижил үүрэгтэй төвүүд юм уу. Эсвэл энэ 2 ажлаа яаж ямар зарчмаар ингэж ялгаж ажиллах юм бэ. Энийг сайн ойлгуулаад өгөөч. Би бас зарчмыг нь мэдэхгүй байна. Ажлын хэсгээс асуух уу дарга аа.

П.Ганзориг: Энхнасан гишүүний асуултад ажлын хэсгийн 7 номероос хариулъя. П.Батчулуун зөвлөх.

П.Батчулуун: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Энэ асуудал дээр олон хүмүүс бас эргэлзээ төрөөд байдаг. Манай Улсын 1 дүгээр төв эмнэлгийн хашаанд

баригдаж байгаа Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төв маань бол яг үндсэн үйл ажиллагаа нь бол нөгөө мэс заслынхаа эмчилгээ, үйлчилгээ хийх төв байгаа юм. Энэ төв маань бол 2019 онд одоо ер нь концепц нь гарч баригдахаар ингэж шийдэгдээд, одоо Улсын 1 дүгээр төв эмнэлгийн хашаанд баригдаад, 10 давхар орчим байшин болж байгаа. Энэ нь бол эмчилгээ, үйлчилгээ явуулах ийм төв байгаа юм. Манай албаны буюу Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах мэргэжлийн төв нь бол энэ эрхтэн үйл ажиллагааг нийтэд нь зохицуулах донор болон донорын эрхтнийг хуваарилах, амьгүй донорыг илрүүлэх, бусад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд оролцож байгаа багуудын хүний нөөцийг бэлдэх асуудал мөн багуудтайгаа хамтарч журам, удирдамжуудыг боловсруулах зэрэг Эрүүл мэндийн яаман даа энэ үйл ажиллагаануудыг дэмжлэг болгож тусалж ажиллах ийм алба байгаа юм. Энэ 2 бол 2 өөр чиг үүрэгтэй, ойролцоо нэртэй ийм 2 өөр чиг үүрэгтэй байгууллагууд байгаа юм шүү гишүүд ээ.

П.Ганзориг: Энхнасан гишүүн тодруулъя.

Л.Энхнасан: Тэгэхээр нөгөө Био банк нь хаана байх юм. Аль төв дээрээ байх юм.

П.Ганзориг: Ажлын хэсэг 7 номерын микрофон хариулъя.

П.Батчулуун: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Батчулуун. Бид нар анхнаасаа энэ Био банкны асуудлыг манай алба 2018 онд байгуулагдсанаас хойш Био банкны асуудлыг санал болгоод, ШУТС болон Эрүүл мэндийн яамандаа саналуудыг хүргүүлээд ингээд явсан. Ердөөсөө энэ Био банкиг бол ямар нэгэн байдлаар шинэ байр сав гэхгүйгээр Улсын 1 дүгээр төв эмнэлгийн Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв буюу одоо энэ баригдаж байгаа байрандаа манай цус, ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн үйл ажиллагаатай уялдуулаад энд байрлуулъя гэсэн анхны санаа концепц нь ингэж явагдсан юм.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9-д зааснаар зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Горимын санал байгаа юм уу. Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат гишүүний микрофонд өгье.

С.Эрдэнэбат: Хууль батлагдсантай холбоотой дагаж гарах тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны төслөөр баталъя гэдэг ийм горимын саналыг гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү. Анхны хэлэлцүүлгээр нь шууд эцэслэн батлах саналыг оруулж байна.

П.Ганзориг: Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Мөнхтуяа гишүүн ороогүй байна. Чинбүрэн гишүүн ороогүй байна. Санал хураалтдаа бэлтгээрэй. Болормаа гишүүн санал хураалтдаа бэлтгэе.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад нийт 21 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 81 хувиар батлагдлаа.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа танилцууля.

14.04 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууля.

Ажлын хэсэг хэвээрээ. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Б.Баярбаатар: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүддээ маш их талархаж байна. Тэгээд энэ Баасан гаргийн өглөө 10 цагаас хууль болон дагах хуулиуд энэ тогтоол эцэслэн батлах санал хураалт 64 гишүүн дэмжиж, батлагдах ёстой байгаа. Тэгээд энэ дээр манай гишүүд бас хариуцлагатай оролцож, хуулийг эцэслэн батлах, энэ анхдагч хуулийг амь оруулах энэ ажлыг бас санал өгч, баталж өгөхийг хүсье.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 42.8 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Ганзориг: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасан. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Эрдэнэбат гишүүн горимын санал.

С.Эрдэнэбат: Дагах хуультай холбоотой Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай холбоотой зарчмын болон санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэг рүү шилжүүлж, эцэслэн батлах саналыг гаргаж байна. Горимын саналыг гаргаж байна.

П.Ганзориг: Горимын санал гаргасан. Тэгээд гишүүд санал хураалтдаа бэлдье. Бейсен гишүүн санал хураалтдаа бэлтгэе. Өөр бусад гишүүд орчихсон байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбатын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад 22 гишүүн оролцоноос 18 гишүүн дэмжиж, 81,8 хувиар дэмжигдлээ.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Мөнхтуяа гишүүн танилцуулах уу. Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлт, шийдвэрийн төслийн хамт Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг танилцуулна.

14.10 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нарын 4 гишүүнээс өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя. М.Оюунчимэг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Төрөлжсөн мэргэжлийн тусламж хариуцсан ахлах шинжээч, Б.Нарантуяа ЦССҮТ-ийн захирал байхгүй юм байна. Н.Халиун ЦССҮТ-ийн Үйлдвэрлэлийн тасгийн технологич их эмч, Э.Тунгалагтуяа ЦССҮТ-ийн Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга.

Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Жадамбаагийн Баясгалан гишүүн танилцуулна.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Хоцорсонд уучлаарай.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулга.

2026 оны 5 дугаар сарын 5.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 253 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангаар ахлуулж, гишүүдэд Баярбаатар, Энхнасан, Болормаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат нар ажиллалаа.

Мөн ЦССҮТ-ийн ажилтнууд, төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий бүрэлдэхүүн ажиллалаа.

Ажлын хэсэг болон ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий бүрэлдэхүүн өнгөрсөн хугацаанд нийт 18 удаа хуралдсан болно.

Ажлын хэсэг хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлт, Эрүүл мэндийн яамнаас болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналуудыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлт гаргах хүрээ хязгаарт багтаан төслийн үзэл баримтлалын хүрээнд зүйл, хэсэг, заалт нэг бүрээр ярилцаж, дараах агуулга бүхий 62 зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг бэлтгэсэн болно.

Ажлын хэсэг уг хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтүүдийг нэмж тусгахаар томъёоллоо. Тухайлбал,

1.Цусны донорын тухай хууль тогтоомжийн нэр томъёоны тодорхойлолтын үг хэллэгийг ойлгоход хялбар, энгийн, салаа утгагүй байдлаар илүү нарийвчлан томъёолж, хуульд хэрэглэгдэж буй цусны сонор сэрэмжийн тогтолцоо, байнгын донор зэрэг зарим нэг нэр томъёоны тайлбарыг тодорхойлолтод нэмж тусгалаа.

2.Хуулийн хэсэг, хуулийн үйлчлэх хүрээг шинээр тодорхойлж Монгол Улс улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн харьяалалгүй хүний эрүүл мэнд, амийг аврах зорилгоор цус сэлбэх тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг тусгалаа.

3.Монгол Улсад төдийгүй дэлхий нийтэд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгаль, цаг уур, биологийн гаралтай аюулт үзэгдэл, гамшиг ослын тоо, давтамж, түүнээс учрах хохирол жил бүр өсөн нэмэгдэж байгаа энэ үеийн хүний эрүүл мэнд, амь насыг аврахад нэн шаардлагатай цус, цусны бүрэлдэхүүний нөөцийн бэлэн байдлыг хангах нь гамшгийн сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд энэ талаарх заалтыг илүү тодорхой тусгалаа.

Түүнчлэн цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг сайжруулах асуудлын хүрээнд нарийн мэргэжлийн ур чадвар, тасралтгүй сургалт, хөгжлийг шаарддаг эрсдэлтэй, өндөр хариуцлагатай нөхцөлд ажилдаг цус сэлбэлт судлалын салбарын ажилтнуудад ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох заалтыг нэмж тусгалаа. Ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг олгосноор тус салбарт ажиллагсдын нийгмийн баталгааг дээшлүүлж, албандаа итгэх итгэл, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн хомсдолоос сэргийлэх боломж нэмэгдэнэ гэж үзсэн.

4.Цусны донорт тавигдах шаардлага, эрх, үүргийн асуудлыг олон улсын жишиг зарчимд нийцүүлэн томъёолсон.

5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн Ассамблейн VHA 63122010 тогтоолын дагуу сайн дурын авлагагүй байх зарчмуудыг хуулийн төсөлд мөрдлөг болгон тусгасан.

6.Цус сэлбэлт судлалын салбарын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо үйл ажиллагааг илүү тогтвортой болгох үүднээс цусны донорын үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтнүүдийн үүргийг нарийвчлан тодорхойлсон болно.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналуудыг та бүхэнд хүргүүлсэн тул хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан.

П.Ганзориг: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т “Байнгын хороо хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцэнэ.” гэж заасан. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгийн саналтай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилгоор сайн дураар цусаа үнэ төлбөргүй өгөх болон цусны донорын үйл ажиллагаа, цусны аюулгүй байдал, бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Д.Баярбаатар, Л.Энхнасан, Х.Болормаа, Д.Рэгдэл, У.Отгонбаяр, М.Сарнай, С.Эрдэнэбат /цаашид “ажлын хэсэг” гэх/.Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтдаа ороогүй, бэлтгээгүй гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт. Санал хураалтад нийт 23 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, санал 73,9 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Ганхүлэг гишүүн, Ганмаа гишүүн бас байгаа юм байна. Орохгүй байна уу. Ганхүлэг гишүүнээр тасалъя. Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Би энэ хуулийн 2.1-тэй холбоотой асуулт асуумаар байгаа юм. Тэгэхдээ энэ төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дээр Монгол Улсын олон улсын гэрээ, олон улсын гэрээний тухай хууль гэснийг хасах гэдгээр санал асуух гээд байна уу. Тэгвэл би энэ асуултаасаа татгалзлаа.

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Энэ дээр жоохон тодруулчихдаг юм уу. Яагаад хасаж байгаа юм бол. Монгол Улсын олон улсын гэрээ гэдэг нь бас юуг илэрхийлж байгаа юм бол. Тодорхой энэ бас олон улсын гэрээ контракттай холбогдолтой асуудал бас хөндөгдсөнийг ингээд хасчхаж байгаа юм болов уу гэсэн ийм тодорхойгүй байдал байна л даа. Энэ дээр тодруулчихъя.

П.Ганзориг: Ажлын хэсгээс 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Энэ саяын асуулт дээр тодруулга хийе. Энэ 2.1 дээр анх төсөл дээр Монгол Улсын олон улсын гэрээ, олон улсын гэрээний тухай хууль гэж заасан байсан. Энэ яг агуулгаараа энэ цус сэлбэх асуудал бол өөрөө бас олон улс дээр тавигддаг ийм бас дүрэм журмууд байдаг. Ялангуяа гамшиг ослын үед, яаралтай үед улс орнууд харилцан бие биедээ шаардлага хангасан стандартын цус, цусан бүтээгдэхүүнээр хангах энэ олон улсын гэрээ хэлэлцээрүүд байдаг. Тэгэхдээ энэ асуудлыг тэр чигээр нь хасаагүй, ер нь утга давхацсан гэдэг утгаар энэ 2 дугаар зүйлийн 2.2 дээр Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэдэг байдлаар тусгаж өгсөн байгаа.

Мөн 3.2 дээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэнд, амь насыг аврах зорилгоор цус сэлбэх тусламж үйлчилгээ үзүүлнэ гэдэг байдлаар энэ хууль дээр илүү тодруулж өгсөн учраас энийг яг энэ 2.1 дэх заалтаас хассан байгаа.

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн тодруулах уу. Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Зүйл заалтыг бол ойлголоо. 1 юм тодруулчихдаг юм уу. Гадаад хүн Монголд байж байгаад цусаа өгч болдог юм уу. Эсвэл Монгол хүн гадаадад явж байгаад өгч болдог юм уу. Энэ болохоор яах вэ, олон улсын хэлэлцээр, янз бүрийн зүйлээрээ бас нээлттэй байдаг уу. Энэ хууль дээр бас тиймэрхүү асуудал тусгагдаж байгаа юу.

П.Ганзориг: Ажлын хэсэг 5 номер дээр хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Уучлаарай. Би Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр. Ганхүлэг гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ дээр бол ер нь бол гадаад улсын иргэн Монгол Улсад цусаа өгөх нээлттэй байгаа. Гэхдээ бид нар цусны аюулгүй байдлыг хангах үүднээс 6 сараас урт хугацаагаар амьдарч байгаа иргэнийг цусаа өгөх боломжийг Эрүүл мэндийн сайдын журмаар зохицуулж явж байгаа. Монгол Улсын иргэн мөн гадаад улс дээр очоод тухайн улсын тавигддаг

цусны донор хүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа тохиолдол дээр цусаа өгөх бүрэн боломжтой байгаа. Энэ бол яг зохицуулга нь бол нээлттэй байдаг.

П.Ганзориг: Түрүүн Ганмаа гишүүн асуулт асуух байсан юм байна. Тэгээд 2 дугаар зүйлтэй холбогдуулан Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Энэ 2.1-д ерөнхийд нь асуухад хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулиас энэ хуулийг ингээд тусад нь авах ерөөсөө боломжгүй юм шиг надад санагдаад байгаа байхгүй юу. Одоо энэ 2.1-д жишээлбэл яагаад энэ хуулийг оруулаагүй юм. Тэр дээр бичсэн хуулиудыг ингээд хууль эшилдэг шүү дээ. Үндэслэл, үзэл баримтлал, тэр эшлэл дээр ч гэсэн энэ хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг огт дурдаагүй, эшлээгүй, орхигдуулаад явчихсан нь санаандгүй юм уу, санаатай юм уу. Яагаад ингээд бүр орхигдчихсон юм бол гэж гайхаад байна л даа. Энэ 1 дүгээрт энэ чинь хууль зүйн уялдааны зөрчил биш юм уу. Жишээлбэл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлтэйгээ зөрчилдөөд байна.

2 дугаарт энэ чинь Үндсэн хуулийн зөрчил байгаа юм шиг харагдаж байна. 16.17-д хувь хүний нууцыг хуулиар хамгаалах эрхтэй гэж заачихсан байгаа шүү дээ. Дээрээс нь энэ практик дээр ч гэсэн зөвхөн хууль, эрх зүйн хувьд биш практикийн хувьд энэ боломжгүй юм биш үү. Энэ хариуцлага, технологийн стандарт, хяналтын механизм энэ тэр нь бүгд тодорхойгүй болгож орхигдсон юм шиг сэтгэгдэл төрөөд байна л даа. Тэгэхээр энэ хуулийнхаа төслийн 2.1-д Цусны донорын тухай хуулийн тогтоомжийн жагсаалтад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай гэдэг энэ хуулийг заавал оруулах хэрэгтэй юм шиг санагдаад байна. Тэгэхгүй бол энэ цусны донорын мэдээллийн санд цуглуулах мэдээлэлд чинь цусны бүлэг, резус фактор, HIV, гепатитис, шинжилгээний үр дүн, удамшил, бэлгийн зан үйл бүх мэдээллүүдийг тэр тусмаа хувь хүний эмзэг мэдээлэл бүхэлдээ хамрагдаж байгаа. Тэгээд энэ эмзэг мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн сан болгох, хадгалах, дараа нь тэр донор нь өөрөө тэрийгээ хэзээ мэдээллээ устгуулах вэ, хэрэглэх вэ, засах вэ, янзлах вэ гэдэг дээр яаж энийг оролцуулах юм гэдэг энэ бүх юмнууд ингээд тодорхойгүй хаягдчихсан сэтгэгдэл төрөөд байна л даа. Энэ хүний эмзэг мэдээлэлд чинь саяын тэр эрүүл мэндийн мэдээллээс гадна биометрикийн мэдээлэл орно. Тэгээд хувь хүний нөөцөд хамарсан нэлээн олон юмнууд байна.

Дээрээс нь эрүүл мэндийн ажилтны хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд бас эмзэг мэдээллийг ашиглаж болно гэдгийгээ яаж оруулж байгаа талаар тодорхой тайлбарлаж өгөхгүй юу.

П.Ганзориг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 5 номер Эрдэнэбаяр Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Энэ яг 2.1 дээр бол яг тухайлан хуулийг зааж өгөөгүй байгаа. Гэхдээ хуулийн агууламж дотор тухайлбал хуулийн 14.3.1 дээр хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 18.2.7-д заасан мэдээллийг холбогдох эмнэлгийн мэргэжилтэнд үзүүлэх гэдэг байдлаар бас тусад нь нэмэлтээр тусгаж өгсөн байгаа. Тэрнээс гадна хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дээр цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор цусны донорын мэдээллийн сантай байна гээд. Тэгээд энэ мэдээллийн сангаа бас тодруулаад энэ дээр Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын

гишүүн хамтарсан байдлаар журам батална гэдэг байдлаар бас тусгаж өгсөн байгаа.

П.Ганзориг: Ганмаа гишүүн тодруулах уу. Нэмээд хууль санаачлагч Чинбүрэн гишүүн бас нөгөө хуулийн үзэл баримтлалтай холбоотой асуудал хөндөж байгаа болохоор бас хариулбал зүгээр байна. Тэгэхээр Чинбүрэн гишүүн хариулаад, шаардлагатай бол Ганмаа гишүүн тодруулаад тавьчихъя. Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Ер нь бол энэ мэдээллийн нууцлал бол чухал зүйл байгаа. Тийм учраас Ганмаа гишүүний асууж байгаа зүйл бол зөв байна. Тэгээд бид сая Эрдэнэбаяр Төрийн нарийн бичгийн даргын хэлдгээр энэ хуульд уг нь бол тусгайлан зүйл заалт болоод оруулчихсан учраас заавал анхны эшлэл дотор энэ орох нь зөв эсэхийг яг хууль, эрх зүйн чиглэлээсээ мэргэжлийн хуульчид бас энэ дээр саналаа хэлнэ биз. Зүгээр миний ойлгож байгаагаар бол бид энд бусад хууль тогтоомж гээд орчихсон байгаа. Тэгээд араас нь эшилчихсэн байгаа учраас заавал ингэж энэ хэсэгт нь оруулж өгөх хэрэг байна уу, үгүй юу гэдгийг бол илүү байх л гэж би бодож байна.

П.Ганзориг: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Би ингээд бүр нарийвчлаад л асуугаад байна л даа. Энэ 25.1-ийг сая Төрийн нарийн хэлж байна. Тэр 25.1 дээр бас өөр дээр нь бас асуудлууд байгаад байгаа байхгүй юу. Энэ дээр миний бодлоор ерөөсөө тэр хувь хүний мэдээлэл дээр чинь наад зах нь цус аваад, тэр дээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийхэд хүртэл тэр чинь мэдээлсэн зөвшөөрөл буюу информент консент гэж нэг юм авдаг тийм үү. Тэр мэдээлсэн зөвшөөрөл дээрээ бүр үг, үсэггүй яг юуг нь яаж, ямар байдлаар аваад, хаана хадгалаад, юу хийгээд, тэр мэдээлэл нь цаашаа яах вэ гэдэг бүр нарийвчилсан юмнуудыг бичгээр 2 талд үйлдээд, гар хөлийн үсэг зураад, тэрийгээ бүр бүр цаашдаа тусгай файлд хадгалаад, янз янзын асуудал гаргаж ирвэл аудитын ч юм уу бусад байдлаар гаргаж ирдэг шүү дээ. Одоо тэр нарийвчилсан информ консент эд нар юм өгөх үү, өгөхгүй юу. Энэ информ консент дээр байгаа энэ мэдээ мэдээллийг дараа нь тухайн хүн ч юм уу, донор өөрийнхөө өгсөн цусыг сайн дурын үндсэн дээр хаашаа ашигласан юм, юунд хэрэглэсэн юм, эрдэм шинжилгээний өгүүллэг болсон юм уу. Магадгүй ашгийн хувьд зардаг ч юм уу, үрдэг ч юм уу, юманд ашигласан юм уу. Эдгээр мэдээ мэдээллийг авах шаардлага гарвал аль эсвэл өөрийнхөө тэр мэдээллийн санд хадгалж байгаа мэдээллээ устгамаар байвал, өөрчилмөөр байвал, эмзэг мэдээллээ засуулмаар байвал хаашаа, хэнд хандаж янз янзын алдагдал гарвал хэн хариуцлагыг нь хүлээх юм бэ гэдэг дээр тэгвэл асууя. Яагаад гэхээр энэ эшилсэн хуулиуд дотор чинь хамгийн гол хуулиа та нар эшлээгүй орхичихсон байна гэж хэлээд байна шүү дээ. Бусад хууль тогтоомж гэж явж болохгүй шүү дээ. Энэ хууль тогтоомж чинь хувь хүний мэдээлэлтэй гол хууль тогтоомжийг 2021 онд болиод өөр нэртэй хууль гаргасан юм байна шүү дээ. Тийм болохоор энэ дунд хийдэл гараад тэр мэдээлэл нь орхигдчихсон юм биш үү гэж би санаа зовоод байна л даа.

П.Ганзориг: Ажлын хэсэг 5 номер. Эрдэнэбаяр Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад нэмэлтээр хариулт өгье. Энэ үнэхээр чухал асуудал байгаа. Бид нар энэ донорын нууцлалыг хадгалах гэдэг бол хамгийн их чухал асуудал байдаг. Яг одоо явж байгаа Донорын тухай хуулийн

хүрээн дээр бол бид нар таниулсан зөвшөөрлийн хуудсыг бол заавал авдаг. Донор бол цусаа бөхийн өмнө 33 асуумж бүхий асуултыг хариулаад, тэгээд энэ дээрээ хэрвээ миний өгсөн энэ мэдээллийг судалгаанд ашиглахыг би зөвшөөрч байна гэдэг ийм юуг чеклэхсэн бол бид нар энийг судалгаанд ашиглах эрх зүйн орчин бүрддэг. Олон улсад байдаг байдлаар бол цаасан болон цахим хэлбэрээр энэ зөвшөөрлийн хуудсыг бол бөглөдөг байгаа. Тэгэхээр бид нар цаашдаа мэдээллийн аюулгүй байдлыг хадгалах чиглэл дээр бол ер нь ганцхан цусны донорын гэлтгүй эрүүл мэндийн салбарт үйлчилгээ авч байгаа нийт ард иргэдийн мэдээллийн санг хадгалах, аюулгүй байдлыг хангах тал дээр бас бодлогын шинж чанартай ийм зүйлүүдийг бид нар дотооддоо ярьж байгаа. Яг энэ 25 дугаар зүйл дээрээ болохоор бид нар таны яг хөндөөд байгаа маш эмзэг ийм асуудлууд байгаа. Энэ асуудлуудыг 2 сайдын журамд тусаж өгнө гэдэг байдлаар нарийвчилж тусаж өгнө гэдэг байдлаар тусгасан байгаа. Хэрвээ шаардлагатай гэвэл бид нар бас ажлын хэсэг дээрээ яриад, яг энэ хувь хүний нууцлалын тухай хуулийг эхний хоёрынхоо 1 дээр бас оруулаад явах боломжтой гэж ажлын хэсгийн зүгээс бас харж байгаа.

П.Ганзориг: Асуулт асууж дууслаа. 2 дахь санал хураалт.

Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, санал 73,9 хувиар дэмжигдлээ.

Наранбаяр гишүүнийг дэмжсэнээр саналыг нь аваарай. Мөн Бейсен гишүүн бас энэ саналуудыг дэмжээд явж байгаа гэдгээ илэрхийлсэн байгаа.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

3 дахь санал хураалт.

Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилтын хүрээнд цусны донорын үйл ажиллагааг зохион байгуулах, цусны аюулгүй байдлыг хангах, цус сэлбэлт судлалын салбарын бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэнд, амийг аврах зорилгоор цус сэлбэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Цаасаар тараагдсан материал дээр зарим үсэг нь гараагүй, уншихад жоохон төвөгтэй асуудал үүсэж байна шүү.

Санал хураалтад нийтдээ 24 гишүүн оролцсоноос 19 гишүүн дэмжиж, 79,2 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “цус” гэснийг өмнө “цус, цусны бүрэлдэхүүн хэсэг” гэж, мөн заалтын “аюулгүй байдлыг хангахтай” гэснийг “аюулгүй байдал, сонор сэрэмжийн тогтолцоотой” гэж өөрчилж, мөн зүйлийн 3.1.2 дахь

заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 19 гишүүн дэмжиж, 79,2 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 3.1.4 дэх заалт нэмэх:

“3.1.4.“цусны байнгын донор” гэж жилд тогтмол хоёр ба түүнээс дээш удаа цусаа өгсөн хүнийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 19 гишүүн дэмжиж, санал 79,2 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах зорилгоор” гэснийг, мөн зүйлийн 3.1.8 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 19 гишүүн дэмжиж, 79.2 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “биобэлдмэл” гэснийг “бэлдмэл” гэж, мөн заалтын “цус, цусны бүрэлдэхүүн хэсгээс” гэснийг “цусны сийвэнгээс” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 3.1.10 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 19 гишүүн дэмжиж, санал 79,2 хувиар дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх:

“3.1.12.“цусны сонор сэрэмжийн тогтолцоо” гэж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг авах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх явцад гарах сөрөг урвал, хүндрэлийг илрүүлэх, шуурхай арга хэмжээ авах, сэргийлэх цогц үйл ажиллагааг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, санал 70,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Нэг асуулт байна. Миний ойлгож байгаагаар цусны донорын хомсдолын асуудал бол энэ салбарын бас нэлээн тулгамдсан чухал асуудал байдаг юм байна гэж би ойлгоод байгаа юм. Тэгэхээр энэ хууль гарснаар энэ цусны донорын хомсдолын асуудлыг шийдвэрлэхэд ямар ач тустай байх вэ гэдгийг нэгд тодруулмаар байна.

2 дугаарт тогтмол донор нь илүү байнгын тогтмол донор түрүүн тэр 3.1.4 дээр ярьсан байнгын донор жилд 2 ба түүнээс дээш удаа цус өгдөг хүнийг тогтмол донор гэдэг юм байна. Яагаад хүмүүс тогтмол донор болохгүй байгаа юм бэ гэдэг зүйлийг та бүхэн бодвол судалсан байдаг байх. Тэгэхээр бодвол сурталчилгаа энэ тэр янз бүрийн юм хэрэгтэй байдаг болов уу. Нөгөө талдаа түрүүн Ганмаа гишүүн бас хэлж байна. Тэр хүний цусанд хүний ДНХ-ийн болоод бусад бүх мэдээлэл байгаа шүү дээ. Намайг хэний хэн бэ гэдгийг бүр хэдэн мянган жилийн түүхээр гаргаад ирэх ийм мэдээлэл. Тэгэхээр энэ хувийн мэдээллээсээ болоод байдаг юм уу. Эсвэл магадгүй уламжлалт янз бүрийн ухамсар сэтгэлгээ, ёс заншил элдэв зүйлээс болоод байдаг юм уу. Ер нь донорын хомсдол яагаад байгаад байдаг юм бэ. Энэ хомсдолоосоо яаж арилах юм бэ. Энэ хууль маань донорын хомсдолоос арилгахад ямар хувь

нэмэр оруулах юм бэ гэдгийг хэлээд өгөөч. Тэгээд үргэлжлүүлээд дараа нь хариултаа авсныхаа дараа бас нэг тайлбар хэлмээр байна.

П.Ганзориг: Ажлын хэсгийн 5 номерын микрофон хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Ер нь одоо бол Донорын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. 2000 онд анх батлагдсан. 2012 онд нэмэлт, өөрчлөлт орж, 2018 онд шинэчлэн найруулагдсан байгаа. Тэгээд 2021 онд бас нэмэлт, өөрчлөлтүүд орж ингэж явсан. Тэгээд энэ хуулиар бол 2 асуудлыг зохицуулж байгаа. Ер нь цусны донорын тухай асуудал энэ хуультай болсноороо бол Монгол Улсад цусны аюулгүй байдал хангахад бол онцгой түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Өнөөдөр бид нар бас яг дангаараа одоо хуультай болж өгснөөр цаашдаа бас үнэхээр өсөн нэмэгдэж байгаа энэ хэрэгцээг хангахад бол чухал шаардлагатай ийм хуулийн зохицуулалт болж байгаа. Энэ ганцхан цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хэрэгцээ гэдгээс гадна бас энэ чиглэлээр ажиллаж байгаа эмч ажилтнуудын цалин хөлс, нийгмийн асуудал гээд олон асуудлуудыг тусгаж өгснөөрөө бас ийм онцлог хууль болсон байж байгаа.

Ер нь бид нар энэ хүн амын дунд мэдлэг, хандлага, дадлын судалгааг 2 удаа үе шаттай хийсэн. Энэ хуулийг хэрэгжихээс өмнө бас хийж үзэхэд бол ер нь хүн амын дунд энэ цусаа өгөхийн ач холбогдлыг ойлгох талаар хүмүүсийн мэдлэг, хандлага, дадал бол хангалтгүй байна буюу ер нь хүн амын 40 хувь нь тодорхой ойлголттой байна. 60 хувь нь ямар ч ойлголтгүй байна гэдэг ийм судалгааны үр дүн гарсан. Энийг 4 жилийн давтамжтай дахиж хийхэд бол 60 хувь болж нэмэгдсэн байсан. Ахиад цаана нь 40 хувьд хүргэх асуудлууд байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар цусны донорын үйлсийг сурталчлах, энэ үйл ажиллагааг олон нийтэд таниулахад бол тодорхой хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх гэдэг юм уу олон ийм тулгамдсан асуудал өнөөдрийн мөрдөгдөж байгаа хууль дээр бас дутагдалтайтай байгаад байгаа. Тэгэхээр энэ хууль дээр энийг илүү тодруулж өгснөөрөө бол бид нар цаашдаа хэрэгцээгээ хангах юм байна. Ер нь гамшгийн үеийн нөөцийг бүрдүүлэх энэ тэр ажлууд ч гэсэн бид нар дээр тодорхой үе шаттай явагдаж байгаа боловч яг өнөөдрийн түвшинд бас хангалттай гэж хэлэх түвшинд бас очиж чадаагүй байгаа. Тэрнээс гадна яг орчин үед бид нар яаж байна гэхээр энэ цусны сийвэнгийн бүтээгдэхүүн буюу энэ давтан өгөөд байгаа энэ бүтээгдэхүүнүүдийг ашиглаж, тэндээс одоо альбумин, иммуноглобулин зэрэг бас яг эмчилгээний шаардлагатай энэ бүтээгдэхүүнийг гаргаж авах нөөц бололцоо бол байдаг. Монгол Улсын хувьд бол хараахан ийм нөхцөл одоогоор бүрдээгүй байгаа. Тэгэхээр цаашдаа бол энэ нөхцөл бололцоо бүрдвэл бас бид нарт нэлээн өндөр ач холбогдолтой болно гэж бас ингэж харж байгаа.

Байнгын донор гэдгийг бол яаж байна гэхээр ер нь бол тогтмол хугацаанд л цусаа өгч байгаа хүмүүсийг байнгын донор гэж нэрлээд байгаа. Тэгээд энийгээ бид нар яг энэ хууль дээр бүр тусгаж өгч байгаа. Өнөөдрийн хууль дээр ч гэсэн ер нь жилд 2 түүнээс дээш удаа өгснийг байнгын донор гэдэг байна гэдэг байдлаар томъёолсон байж байгаа.

П.Ганзориг: Бум-Очир гишүүн тодруулъя.

Д.Бум-Очир: Тэгэхээр өнөөдрийн энэ хуралдааныг ч гэсэн олон нийт үзэж ажиглаж байгаа байх гэж бодож байна. Цусны донорын тухай хуулийн асуудал хэлэлцэж байна. Миний ойлгож байгаагаар цусны донорын нөөцийг хэвийн болгож, цаашдаа нэмэгдүүлэхийн тулд цусны байнгын донор олон болох ёстой юм байна

гэж би ойлгоод байгаа юм. Нэг шийдэл нь. Тэгээд жилд хэрвээ хүн 2 болоод түүнээс дээш цусаа өгөөд байнгын донор болчихдог юм бол би бас жаахан судалж уншлаа. Хамгийн үр дүнтэй арга бол энэ цусаа өгөх аян санаачилж хэрэгжүүлэх байдаг юм байна. Тэгэхээр энэ цусны байнгын донор болох зүгээр 1 удаа өгөх биш шүү, байнгын донор болох аян хийгээд, одоо бол хийж байгаа байх та нар энэ аянаа манай парламентын 126-аас эхэлчхэж болох юм юм шиг санагдаад байх юм. Би бол өгнө. Мэдээж янз бүрийн эрүүл мэндийн болоод олон шалтгаанаар өгөхгүй хувийн мэдээллээ хадгалах гэсэн олон шалтгаанаар өгөхгүй хүн байхыг үгүйсгэхгүй. Тэр хүмүүсийн байр суурийг хүндэтгэж байна. Миний мэдэхээр бол манай 126 дотор лав нэлээн хэдэн хүн өгөх байх. Бид бас нийгэмдээ үлгэр дуурайлал болоод, тэгээд жилд 2 удаа бид нараас ирээд авчхаач ээ. Энэ 126-аас ядаж 70, 80 хүн өгчихвөл бас тодорхой хувь нэмэр оруулах байх. Гол нь энэ 70, 80 хүндээ гол нь биш, энэ олон нийт, ард иргэдэд зөв ойлголт өгөх, байнгын цусны донор болох энэ хөдөлгөөн өрнүүлэхэд бидний магадгүй санаачилга гэж хэлэх үү дээ. Хэрвээ энэ ажил хэрэг болж чадвал бас чухал үр дүнтэй байж болох болов уу гэж бодогдож байна. Бусад гишүүд маань, Байнгын хорооны дарга юу гэж бодох юм байгаа юм. Их Хурал дээр бас энийг ярьж болох болов уу гэж бодож байна. Ордонд ирээд авчихвал зөвхөн энэ 126 гишүүн биш Тамгын газар ажиллаж байгаа, энэ ордонд ажиллаж байгаа олон хүмүүс биш шүү дээ. Ирээд авна гэвэл тэр үед нь хурал цуглаангүй байж байгаа үед ороод тэгээд 1 жилд 2 удаа өгчих бол асуудалгүй юм шиг л санагдаж байна. Тэгээд ийм байдлаар олон хүнтэй бусад байгууллагуудыг байгууллагаар нь байнгын донор болгох хөдөлгөөн өрнүүлээд явбал та бүхэн дэмжлэгтэй байх болов уу гэж бодсоны үүднээс хэлж байгаа юм.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч нэмж хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Баясгалан гишүүний микрофоныг нээе.

Ж.Баясгалан: Гишүүндээ баярлалаа. Тэгээд яг энэ цусны донор ер нь донорын гол асуудал бол сайн дураар гэж явдаг. Тийм болохоор бид нар сурталчилгаа ямар нэгэн юм хийхэд бол бас тодорхой хэмжээтэй байхгүй бол энэ нь өөрөө ямар нэгэн сэдлийг төрүүлдэг гэдгээрээ бас нөгөө талдаа бас хоригдож байдаг. Тэгээд 21 аймгийн эмнэлэг болоод цусны төвөөр бас ажлын хэсэг бол явж ажилласан өнгөрсөн онд бид нар. Дээр нь нэмээд ажлын хэсэг болоод Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд маань өөрсдөө Цусны төв дээр очиж бас цусаа өгсөн. Тэгээд цусаа өгөөд, яг тэр цусны төвийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан байгаа. Тэгэхээр яг таны хэлж байгаа бол нөгөө талдаа бол үнэн. Бид нар бол гадаадын иргэн ч гэсэн 6 сар байх ёстой гэж үзээд байна шүү дээ. Яг тэр шиг олон удаа өгдөг байнгын донортой болох тал дээр илүү энэ мэдээ мэдээллийг түгээж, хүн өгөх өөрийнх нь зорилго, урмыг нь бадраах тэр талдаа илүү ажиллах ёстой гэж бодож байна. Тэгээд таны саналыг хүлээж авч байна.

П.Ганзориг: Хууль санаачлагч Чинбүрэн гишүүн нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Бум-Очир гишүүн ээ, энэ дээр нэг ийм зүйл байгаа. Нэгд аюулгүй байдал гэж байгаа. Тэгэхээр яагаад бид ингээд олон хүн сайн дурын донор тогтмол донор болж чадахгүй байгаа юм гэхээр нэгд архаг гепатит вирустэй эсвэл бэлгийн замын халдвар байх юм уу, янз янзын зүйл байх юм бол энэ цусыг нь авахгүй байх энэ тохиолдол их өндөр байгаа шүү.

2 дахь чухал зүйл бол бид урамшууллын тогтолцоо гэж ярихаар энэ үнэгүй учраас бид яах ёстой вэ гэхээр сайн хоол өгөх, ирэхэд нь унааны зардлыг нь өгөх ч

гэдэг юм уу эсвэл ажлаасаа чөлөө аваад, цалинтай чөлөө аваад би цусаа өгөх гэж явж байгаа гэдгийг нь дэмжих гэх мэтчилний ийм урамшууллын тогтолцоог зөв хийж өгөх юм бол бид олон олон донортой болох боломж бүрдэнэ. Тэгэхээр 1 талдаа аюулгүй байдал нөгөө талдаа олон нийтэд сайн сурталчлах ёстой. Тэгэхээр энэ хуулийн ажлын хэсэгт би баярлаж байна. Бас нэг сайн хийсэн зүйл бол энэ урамшууллын тогтолцоонд энэ сангаас зарцуулах боломжийг, мөнгө зарцуулах боломжийг бас гаргаж өгөхгүй бол мөнгөгүй яаж сурталчлах юм. Тийм ээ. Сурталчилгаа хийх боломж байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бас энэ талын зүйлүүдийг дараа дараагийн санал асуулга дээр орж ирэх учраас та бүхэн бас дэмжээд яваасай гэж хүсэж байна.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

9.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтыг хасах:

“4.1.3.чанар, аюулгүй байдлыг хангах;” гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

10.Төслийн хоёрдугаар бүлгийн нэрийн “ТОГТОЛЦОО” гэснийг “УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ” гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдал, цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай холбоотой төрийн хяналтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллага хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “, цусны биобэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэх” гэснийг хасаж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Ганмаа гишүүнээр тасаллаа. Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: 6.1.7. Энэ дээр эшлэлийн алдаа байх шиг байсан юм. Тэгэхдээ засчихсан байж магадгүй. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд хамаарсан зүйлийг гэххээд 12 дугаар зүйлийн 12.1 гэж эшилсэн байгаа байхгүй юу. Тэгээд энэ 12 дугаар зүйлийг нь харахаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, ажил олгогчийн эрх үүрэг гэсэн байх юм.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Баясгалан гишүүн хариулъя.

Ж.Баясгалан: 6.1.7-г бол бүхэлд нь хасчихсан байгаа.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

12.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “төрийн бодлогыг Улсын Их Хурлаар батлуулах,” гэснийг “бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн” гэж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын “санхүүжилтийг” гэснийг “түүнтэй холбогдон гарах санхүүжилтийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “гамшгийн” гэсний дараа “болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 58,3 хувиар дэмжигдлээ.

14.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хэмжээг” гэснийг “албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг” гэж өөрчилж, мөн заалтын “, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 58,3 хувиар дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал авах гишүүн байна уу. Алга байна.

15.Төслийн 7 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 62,5 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

16.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “үйл ажиллагааг зохицуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 62,5 хувиар дэмжигдлээ.

Саяын нөгөө өөрчлөн найруулсан саналыг дахиад энэ дотор нь хураах юм байна.

“8.1.2.цусны донорын үйл ажиллагааны талаар баримтлах бодлого боловсруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 62,5 хувиар дэмжигдлээ.

17.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “батлах” гэснийг “баталж, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, мөн зүйлийн 8.1.5 дахь заалтын “орц, илчлэгийн жишиг” гэснийг “зардлын” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал 62,5 хувиар дэмжигдлээ.

18.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “нэмэгдэл цалингийн хэмжээ,” гэснийг “цалин, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл” гэж, мөн заалтын “санал боловсруулах” гэснийг “талаар санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 62,5 хувиар дэмжигдлээ.

19.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг 8.1.7, 8.1.8 дахь заалт болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.7.цус сэлбэлт судлалын салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх;

8.1.8.цусны донорын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх болон өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэндийг дэмжих санд тусгах; Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 62,5 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дахь хэсэг нэмэх:

“8.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 14 гишүүн нь дэмжиж, 58,3 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

21.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хуулийн 15.1.12-д” гэснийг “хуульд” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, 58,3 хувиар санал дэмжигдлээ.

22. Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтын “цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоог” гэснийг, мөн заалтын “удирдлага зохион байгуулалт,” гэснийг тус тус хасах.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 13 гишүүн дэмжиж, санал 54,2 хувиар дэмжигдлээ.

23.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын “сурталчилгааны ажлыг” гэснийг “сурталчилгаа, донорын эгнээг өргөжүүлэх ажлыг” гэж өөрчилж, мөн заалтын “, цусны донор элсүүлэх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ хуулийн заалттай холбоотой бас чухал санал хураалтууд явагдаж байгаа тул Байнгын хорооны гишүүдийг танхимдаа орж ирэхийг бас урьж байна. Ирцэд орсон гишүүд орж ирж, саналаа өгөх хэрэгтэй байна.

24.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь заалтын “биобэлдмэл” гэснийг “бэлдмэл” гэж, мөн зүйлийн 9.3.7 дахь заалтын “талаарх магадалгаа” гэснийг “тухай

тодорхойлолт” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.3.8 дахь заалтын “байгууллага,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 58,3 хувиар дэмжигдлээ.

25.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалтын доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.9.энэ хуулийн 20.1-д заасан донорыг Засгийн газрын шагнал болон бусад шагналд нэр дэвшүүлэх саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 62,5 хувиар дэмжигдлээ.

26.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.3.10 дахь заалт нэмэх:

“9.3.10.цусны байнгын донорт тэмдэг олгох;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 62,5 хувиар дэмжигдлээ.

27.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.10 дахь заалтын “бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх” гэснийг “аюулгүй байдлын талаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.3.11 дэх заалтын “улсын хэмжээнд нэгтгэх,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 58,3 хувиар дэмжигдлээ.

28.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 24 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 62,5 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.4.Цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлд шаардагдах төсвийн зардлаа жил бүрийн улсын төсөвт тусгуулахаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.5.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь дараах байгууллагатай хамтран ажиллана:

- 9.5.1.эрүүл мэндийн байгууллага;
- 9.5.2.төрийн болон төрийн бус байгууллага;
- 9.5.3.аж ахуйн нэгж, байгууллага.

9.6.Хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүд маань бас ирцээ сайн бүрдүүлж байгаа болохоор энэ чухал хуулийн төслүүд маань бас шуурхай явж байна. Байнгын хорооны гишүүддээ бас талархал илэрхийлье.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Наранбаяр гишүүнээр тасаллаа. Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: 1 асуулт байна. Энэ өмнөх зүйлтэй холбогдуулж бас асууна. Яагаад гэвэл энэ 9.4 дээр ийм үг байгаад байгаа юм. Онцгой нөхцөлийн нэмэгдэлд шаардагдах төсвийн зардал гэж. Тэгэхээр энэ эрүүл мэндийн ажилтанд олгох цус сэлбэлтийн судлалын салбарт ажиллаж байгаа энэ эрүүл мэндийн ажилтанд олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл гэдэг энэ үг энд орж ирж байгаа юм л даа. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллага дотор энэ онцгой нөхцөл яагаад яг энэ салбарт хэрэгтэй болоод байна. Онцгой нөхцөлийн нэмэгдэл нь чухам хэдэн хувь байх вэ. Энэ төсөв мөнгө нь бол хэр зэрэг тооцоо хийсэн бэ.

2 дугаарт энэ тэтгэвэр тогтоолгоход жишээлбэл, насыг нь урагшлуулах, илүү залуу насандаа тэтгэвэрт суухад хүргэх ийм зүйл бий юу гэдгийг асуумаар байна. Яах вэ, хуулийн төслийг ингээд харж байхад бол манай улс бол яг одоо идэвхтэй донорын насны хүмүүс нь 50 хувьтай байдаг нь бас ямар учиртай юм бол. Өөрөөр хэлбэл 36-65 насныхан өөрсдөө цус сэлбүүлэгч өвчтөн болж байгаа нь энэ бас ямар учиртай юм. Дэлхийн хандлагаас их өөр юм байна шүү дээ. Энийг бас зүгээр асууя гэж бодсон.

Дээр нь нэмээд яг энэ 2021 оны тоо байна л даа. Донорын тоог 2021 онд 19337 хүн байна гээд ингээд хэлчихсэн. Үүний 7300 орчим нь бол байнгын донор гээд. Одоо энэ тоо энэ чинь 2026 он 5 жилийн дараах бол арай өөр байх ёстой. Энэ нь өсөөд байна уу, буураад байна уу. Энийг сайн мэдэхгүй байна. Тэгээд энэ хуулийн ач холбогдлыг бас би юу гэж харсан бэ гэхээр нэгдсэн удирдлагын тогтолцоонд оруулж байгаа юм байна гэдгийг харлаа. Цус сэлбэлтийн үндэсний төв мэргэжлийн байгууллагын хувьд төсвөөсөө санхүүжүүлдэг боловч эрүүл мэндийн бусад байгууллага буюу орон нутагт ажиллаж байгаа эмнэлэгтээ шууд харьяалагдаад яваад байгаа нь бол бас энэ нийгмийн даатгалын болоод эрүүл мэндийн сангаас санхүүжих нь хүндрэл учраад, тэнд байгаа өрөө тасалгааг нь өөр зориулалтаар ашиглаад гээд юм байгаа. Энийг бол дэмжиж байгаа юм. Яг энэ мэргэжлийн байгууллага нь яг мэргэжлийн юмаа хийгээд явах нь зүйтэй. Ийм учраас яг донорын тоо нь өсөөд байна уу, буураад байна уу гэдэг энэ асуултад бас хариулж өгөөч ээ гэж хүсэх гэсэн юм.

Ер нь зүгээр яг энэ тоон мэдээллүүд энэ хуулийн танилцуулга дээр жоохон хомс харагдаад байна шүү. Яагаад гэвэл энэ цус сэлбэлтийн юу чинь 2035 он гэхэд бараг 200 хувиар нэмэгдэнэ гээд байгаа атлаа яг хэдэн донор хэрэгтэй юм цаашдаа. Энэ хүн амын хэдэн хувьд нь байх ёстой юм гэх мэтийн ийм зүйлүүд бас нэлээн таамаглал судалгаа юмнууд бас учир дутагдалтай харагдаад байгааг бас хэлье.

Тэгээд чуулган руу оруулж ирэх үедээ энэ талын тоонуудаа сайн гаргаж ирэхгүй бол тэр 230 хэдэн хувиар нэмэгдэнэ гэдэг тоог би лав 4 газар олж уншлаа. Дандаа давтагдчихсан. Тэгэхээр зэрэг энэ зүйлүүдээ та бүхэн бас засаж ингэж чамбайруулж оруулж ирэх ийм шаардлагатай байна гэж харж байна. Тэгэхээр ерөнхийдөө энэ хуулийг бол маш сайн дэмжиж байгаа. Зүгээр энэ асуултууд дээр .../минут дуусав/

П.Ганзориг: Ажлын хэсгээс 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ нөгөө цус сэлбэлт судлалын салбар дээр ажиллаж байгаа нийт албан хаагчдыг орон тоогоор нь аваад үзэхээр 206 хүн байгаад байгаа. Тэгэхээр эндээс бас дутуу орон тоогоор ажиллаад байгаа, ялангуяа орон нутгийн түвшин дээр гэдэг юм уу, Цус сэлбэлт судлалын үндэсний төв дээр ч гэсэн бас дутуу орон тоотой яваад байгаа. Энэ бас хэд хэдэн ийм нөлөөлөх хүчин зүйлүүд байгаад байгаа. Өөрөө 1 дүгээрт ийм цөөн хүний хүчээр явдаг ийм онцлогтой салбар байгаад байдаг. Тэгсэн хэр нь хүний нөөцийн тогтвортой байдал хангагдах тал дээр бас асуудал үүсээд байгаа. Яагаад гэхээр тэнд ажиллах сонирхол илүү багатай болчихоод байдаг. Өөрөөр хэлбэл цалин хөлсний энэ байдалтай холбоотойгоор ер нь энэ бол нэлээн их бага байгаад байдаг. Өөрөө энэ салбар нь болохоор яах вэ гэхээр гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах гэдэг юм уу яг онцгой байдал дээр бэлэн байдлыг хангаж ажиллах гэсэн ийм бас чиг үүргүүд байгаад байдаг. Тэгэхээр энэ дээр олон хүнээс санал авсан. Энэ хуулийн явц дээр ялангуяа энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсээс санал авахад ерөөсөө цалин хөлсний байдал бусад яг салбарын эмч ажиллагсдаасаа бага байгаад байна. Энийг бас шийдвэрлэж өгөөч ээ. Бид нар бол илүү нөгөө ашиг юу гэдэг юм гүйцэтгэлээрээ санхүүжих гэхээр энэ дээр үнэхээр бас учир дутагдалтай болоод байна. Ийм онцлог бас байгаад байна. Бэлэн байдлыг хангах гэдэг бол шууд хийсэн бүтээгдэхүүн тэр дороо эмнэлгүүдэд явчихдаггүй. Бид нар нөөцийг бүрдүүлнэ гэдэг бол их чухал байдаг учраас энэ зохицуулалтуудыг хийх хэрэгцээ шаардлагууд гарч ирсэн. Ер нь онцгой байдлын албаны нэмэгдэл бол ер нь 25-40 хувь байдаг юм байна гэсэн ийм бас хуулийн зохицуулалтууд байгаа. Тэгэхээр энийг харж байж бид нар бас яг энэ ажиллаж байгаа хүмүүсийн цаашид олон жил тогтвортой ажиллах гэдэг бол эргээд өөрөө нөгөө цусны аюулгүй байдал гэж бид нар яриад байгаа энэ зүйлийг хийх гинжин хэлхээний хамгийн том хэсэг нь бас хүний нөөцийн асуудал, бэлтгэгдсэн хүний нөөцийн асуудал байдаг учраас сургаж бэлтгэгдсэн хүмүүсээ бас хадгалах энэ гол агуулга бол энэ дээр бас ингэж тусгагдаж явсан байж байгаа. Ер нь жилд цуглуулж байгаа цусны хэмжээ бол жилээс жилд нэмэгдэж байгаа. 2015 оныг сүүлийн 10 жилийн статистикаар аваад үзвэл 30396 байсан 2015 онд байсан бол 2025 онд 46723 удаагийн цус цуглуулалт хийсэн. Тэгэхдээ энэ бол зарим донор давтан өгч байгаа учраас таны түрүүний хэлсэн яг донорын махчилсан тоо нь бол арай цөөнөөр ингэж гарч ирж байгаа. Өөрөөр хэлбэл давтан өгсөн тоонууд ингэж хасагдаж байгаа буюу 1,5 дахин өссөн үзүүлэлттэй байгаа.

Ер нь зүгээр бид нар олон улсын хэрэгцээгээр 2050 он хүртэлх энэ хэрэгцээг тооцож гаргаж ирсэн. Тэгэхээр 2050 он хүртэл бол яг түрүүний таны асуугаад байгаа ийм хэрэгцээ шаардлагууд байгаад байна. Хүн амын өсөлтийн хүн ам зүйн зураглалыг хараад, амьдралын модыг гаргаж ирээд харахаар ер нь бас цонх үе гарах ийм эрсдэлүүд байгаад байна. Тийм учраас бид нар энэ дээр яг хуулийн зохицуулалтаараа нэлээн сайн авч явж байж энэ нөөцийг их сайн бүрдүүлэх, энэ орчныг бүрдүүлэх олон улсад байдаг энэ сайн туршлагуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх хамгийн их чухал юм гэдэг байдлаар энэ заалтууд бас нэлээн их чухалчлагдаж орж өгсөн байж байгаа.

Мөн бас энэ технологийн шинэчлэлүүдийг .../минут дуусав/

П.Ганзориг: Наранбаяр гишүүн тодруулъя. Эхлээд нэмээд хариулчих уу. Нэмэлт гүйцээгээд хариулчих. 5 номер.

Н.Эрдэнэбаяр: Тэгэхээр одоо та бүхэн маань бас мэдэж байгаа. Сая эхний хууль Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль гээд ингээд батлагдаж байгаа. Тэгээд яг энэ хуулийг дагаад өнөөдөр үнэхээр хэрэгцээ шаардлага маш өндөр

байна. Цусны хэрэгцээ энийг дагаад маш өндрөөр нэмэгддэг. Ер нь 1 удаагийн эрхтэн шилжүүлэн суулгахад бид нар тухайн бүлгийн цусыг гэхээс илүүтэй эсрэг бие, эсрэг төрөгчийг тодорхойлж үздэг. Энэ дээр бол яг эмнэл зүйн ач холбогдолтой 10 орчим ийм эсрэг төрөгчийг тодорхойлж үзээд, тухайн хүн 2 дугаар бүлгийн цустай байлаа гэхэд бас ийм бүлэг нь нийцэлтэй донор хэд байх вэ гэдэг нь өөрөө асуудалтай. 500 донороос эндээс таарах 10 донор гарах ийм тохиолдлууд байдаг учраас энэ объектоороо нэлээн өндөр цуглуулж байж ийм өндөр технологийн хагалгаануудын цусыг бэлтгэх бүрэн боломж бүрдэнэ. Тэгэхээр эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаа шаардлагатай маш олон өвчтөн хүлээж байна гэдэг юм уу, бид нар бас Монгол улсад оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнүүдийг үеийн эмчилгээнүүд дээр ялангуяа маш ийм нарийн бүлгийн тохироо, дархлааны тохироонуудыг үзсэн ийм зүйлүүд цус хэрэгтэй байгаа.

Нөхцөлийн нэмэгдлийн хувьд бол ийм байгаад байгаа. Ер нь бол манайх бол цусны төвийн эмч, ажиллагсад бол хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл гэдгээр явдаг. Тийм учраас 10 хувийн нэмэгдэл цалин дээр тооцогддог. Тэгээд нөгөө тэтгэвэрт гарах насан дээр тодорхой хөнгөлөлтүүд, 50 нас гэдэг 50, 55 нас гэдэг хөнгөлөлтүүд бас үйлчлээд явж байгаа. Тэгэхээр энийг илүү баталгаажуулж өгч байгаа л гэсэн үг.

П.Ганзориг: Наранбаяр гишүүн тодруулах уу.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ Цусны донорын тухай хууль ингээд шинэчилсэн найруулгаар орж ирж байгаа нь бол туйлын чухал гэж харж байна. Тэгээд сая энэ Цусны сэлбэлтийн үндэсний төв, яг үүнийг дагасан нэгдсэн ийм тогтолцоо руу орж мэргэжлийн байгууллага нь эндээ ажиллаж байгаа 200 гаран хүн ажилладаг гэж байна шүү дээ. Цаашаагаа нэмэх шаардлагатай байгаа энэ нөхцөлд бол хөдөлмөрийн онцгой нөхцөл гэдэг энэ нөхцөлийг олгож, тодорхой хэмжээнд бодитойгоор бас цалин хөлсний бодлого нь нэлээн сайжрах юм байна гэж ингэж харлаа.

Түүний зэрэгцээ өнөөдөр донорын тоо бас өсөхгүй байгаа юм байна. Гэвч авч байгаа донорын хувь хэмжээ тоо нь нэмэгдсэн. 2015 онтой харьцуулахад бол даруй бараг 10 мянга гаруйгаар нэмэгдсэн байгаа. Тэгэхээр энэ бол бас цаашдаа эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгахтай холбоотойгоор цусны бас донорын асуудал хурцаар тавигдах учраас энэ хууль бол ач холбогдолтой гэж ингэж харж байна. Тийм учраас хуулийнхаа төсөл дээр байж байгаа энэ тоо юмнуудыг сая та хэлсэн тоонуудаараа бас нэлээн сэлбэж оруулж ирж, танилцуулгыг бас чамбайруулахыг би хүсэж байна. Яагаад гэвэл яг сая хэлсэн тоонууд энд ороогүй. Зүгээр л 2035, 2050 он гэхэд ийм болох нь ээ л гэдэг тоо яваад байгаа. Тэр нь бол ингээд харахаар ерөөсөө ДЭМБ-аас өгчихсөн таамаглал юмнууд дээр үндэслээд ингээд явчихсан байна. Тэгэхээр зэрэг та бүхэн энийгээ бас сайн оруулж ирээрэй. Тэгээд манай гишүүд бас яриад байна. Энэ сурталчилгаа, олон нийтэд хүргэх энэ тал дээр бас төсөв мөнгийг нь сайн тавьж өгөөрэй гэж хүсэж байгаа. Энэ хуулийн төсөл дээр энэ өөрөө орчихсон гэж би ойлгоод байгаа. Ингэсэн нь бол бас олон хүний амийг аврах, олон амь нас, олон хүний амьдралд хамгийн хэрэгтэй ийм зүйл болно гэж харж байгаа. Донор их байна, донор нь ийм байна гэдэг чинь нийгмийн дундын баялгийг өсгөнө. Дээр нь нэмээд эрүүл аж төрөх ёсыг дэмжинэ л гэсэн үг шүү дээ. Баярлалаа.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

30.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.3, 15.1.5, 15.1.6, 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллага цусны донорын үйл ажиллагаанд оролцоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Энэ хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд цусны донорын үйл ажиллагаа, цусны чанар, аюулгүй байдлыг хангах, журам, стандарт, зааврыг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

32.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “донор элсүүлэх” гэснийг хасаж, мөн заалтын “тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд” гэснийг “цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 64 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.2.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гарах гишүүн байна уу. Алга байна.

35.Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, ажил олгогчийн эрх, үүрэг” гэснийг “Цусны донорын үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “байгууллагын албан тушаалтан ажил олгогч нь” гэснийг “болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж” гэж, мөн зүйлийн 12.1.3 дахь заалтын “магадалгааг” гэснийг “тодорхойлолтыг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 64 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4 дэх заалтыг нэмэх.

Зүйлээр нь асуучихсан шүү дээ. Тэгэхээр та 13 дугаар зүйлийг хэлэлцэх үед холбогдуулаад асуучих. Сая 37-г би дахиад уншихъя.

37.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4 дэх заалт нэмэх:

“12.1.4.цусны донорын үйл ажиллагааны талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, 56 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, санал 60 хувиар дэмжигдлээ.

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал өгөх гишүүд байна уу. Саранчулуун гишүүн дарчих уу. Саранчулуун гишүүнээр тасаллаа. Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Зүгээр тодруулах зүйл. Энэ 13.1 дээр байгаа нь өөрийн орлого гэсэн юм байна шүү дээ. Санхүүжилттэй холбоотой. Энэ нь яг тодорхойлолтыг нь би олж харсангүй. Яг юугаа хэлж байгаа вэ. Цус нийлүүлсэн орлого юм уу, үйлчилгээний хөлс юм уу. Юуг хэлж байгаа юм.

П.Ганзориг: Ажлын хэсэг хариулах уу. 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр эрүүл мэнд болон сангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн баталсан ийм журам хүчин төгөлдөр явж байгаа. Энүүгээр цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүний жишиг үнийг бас тогтоож өгсөн байдаг. Тэгэхээр энэ үнээр эрүүл мэндийн байгууллагуудыг цус, цусан бүтээгдэхүүнээр хангаж, ингээд тэр бол гүйцэтгэлийн санхүүжилтээр тухайн өвчний онош дээрээ ингээд тусгачихсан байдлаар ингэж явдаг байж байгаа. Тэгэхээр энэ орлогыг өөрийн орлого гэсэн байдлаар ойлгож болохоор байгаа.

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Уучлаарай. Энэ 11.2 дээр асуулт асуух гэж байгаад өнгөрөөчхөж. Энэ нутгийн өөрөө удирдах байгууллага Засаг даргын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг сая хасчих шиг боллоо л доо. Гэхдээ энэ ер нь байх нь бас зөв байсан юм биш үү. Энийг яагаад ажлын хэсгээс хасах санал оруулж ирээд хасчхав. Тодорхой хэмжээнд бас ийм захиргааны зохион байгуулалтын арга хэмжээнүүд бас аваад явж байх нь бас зөв байх.

П.Ганзориг: Ажлын хэсэг 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Таны саяын асуусан дагуу бид нар бас энэ томъёоллыг оруулж ирсэн. Гэхдээ яг хуулийн ажлын хэсэг дээр ярилцаж байх явцад энэ маань бас бусад хуулиудтай утга санааны хувьд давхцаад байна гэдэг байдлаар ингэж гарч ирсэн тул энийг заавал ингэж давхардуулан тусгах шаардлагагүй гэдэг байдлаар хассан байж байгаа.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Баясгалан гишүүн нэмж хариулъя.

Ж.Баясгалан: Гишүүний асуултад хариулъя. Үндсэн хууль болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар эдгээр албан тушаалтан, байгууллага нь ялгаатай чиг үүргийг хэрэгжүүлдэг тул дээрх байгууллага албан тушаалтныг чиг үүргийг тусад нь зохицуулах нь буруу гэж үзээд тэгээд хассан байгаа.

П.Ганзориг: Тодруулах юм уу. Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Яах вэ, нутгийн өөрөө удирдах байгууллагууд Засаг даргын бас чиг үүрэг дээр тэгвэл өөр ямар байдлаар хэдүүлээ оруулж ажиллах вэ. Бас тодорхой донорыг бас дэмжих чиглэлийн, цусны нөөц бүрдүүлэх чиглэл дээр төрийн захиргааны байгууллагын удирдлагууд бас нэг санаачлаад ажиллах л ёстой л доо. Тэгэхээр энийг яах вэ, уг нь буруугүй л заалт байх шиг байх юм. Тэгээд энийг хасчихаар энэ чиг үүргийг тэгээд ер нь яаж тооцно гэж бодсон билээ.

П.Ганзориг: Ажлын хэсэг 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганхүлэг гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ дээр ер нь жил болгон Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулж байгаа. Энэ гэрээ дээр тодорхой заалт болгоод ингээд оруулаад явчих боломжтой гэдэг байдлаар бид нар бас томьёолж харж байгаа.

П.Ганзориг: Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: 2 тодруулах зүйл байна. Төслийн 12 дугаар зүйл дээр цусны донорын үйл ажиллагааны талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ одоо ямар төсвөөр явагддаг юм. Ер нь цаашдаа яаж, эх үүсвэр нь ер нь ямар зохицуулалтаар явдаг юм бэ. Төрийн бус байгууллагын оролцоо энэ дээр байдаг юм уу гэдэг дээр тодруулах гээд байгаа юм.

2-т гэвэл 39 дүгээр зүйл дээр 13.2 дээр иргэний хандив гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо ер нь хандив авагддаг юм уу. Ямар төрлийн хандив орж ирдэг юм. Тэгээд цаашдаа ямар хандивыг энэ дээр ойлгоод байна гэдгийг тодруулах гээд байгаа юм. Тэгээд хариултаа аваад, дахиад тодруулна.

П.Ганзориг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Энэ яг одоо явагдаж байгаа байдлаар бол ЦССҮТ-ийн төсөв дээр бол яг сургалт сурталчилгааны ажлын зардал бол маш бага буюу ер нь энэ дээр бол яг өнөөдрийн байгаа түвшин дээр бол нийт төрийн бус байгууллагууд гэдэг юм уу, аж ахуйн нэгж, компаниуд дээр илүү бас хамтын ажиллагааны хүрээнд энэ сургалт сурталчилгааны ажлууд бол голчилж ингэж явагдаад байгаа. Тэгэхээр энэ хууль дээр өнөөдөр бас энийг бас ингэж явах нь бас буруу юм. Энэ бол бас нэлээн цаашдаа эрсдэл үүсэх юм байна гэдэг байдлаар энэ сургалт сурталчилгаанд холбогдох энэ зардлууд гэдэг бол энэ бас цусны донорыг элсүүлэх, энийг өргөжүүлэхэд бол их чухал ач холбогдолтой гэдэг байдлаар тодорхойлж бас Эрүүл мэндийг дэмжих сангаас гэдэг юм уу ийм байдлаар бид нар бас тодорхой тусгаж өгсөн байж байгаа.

Иргэний хандив гэдэг бол бид нар зүгээр нээлттэй байдлаар орхичихсон. Зарим хүмүүс бас цусны донорын үйлсийг дэмжье, юу гэдэг юм бид нар энэ дээр тодорхой сургалт сурталчилгаа гэдэг юм уу эсвэл ямар нэг байдлаар шторк хийж өгье ч гэдэг юм уу бас тодорхой зардалтай бүтдэг зүйлүүдийг өөрсдөө хийж чадах зүйлээрээ ингэж тусалъя гэдэг ийм байдлаар нээлттэй байх нь зөв юм гэдэг байдлаар тусгасан байгаа. Тэгэхээс яг иргэнээс хандив аваад байдаг ийм асуудал бол байхгүй.

П.Ганзориг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Үргэлжлүүлээд энэ хуультай холбоотой Зөрчлийн хууль дээр зохицуулалт бий юу. Одоо жишээлбэл хуулийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд ямар хариуцлага хүлээдэг юм. 1 дүгээрт.

2 дугаарт нь төрийн бус байгууллагын оролцоо энэ хууль дээр яаж тусгагдаж байгаа вэ. Төрийн бус байгууллагууд ер нь ихэнх хууль дээр бол дандаа тийм зар сурталчилгааны самбар шиг л байдаг л даа. Тухайн хуулийг хүмүүст таниулах сурталчлах гээд л явчихдаг. Уг нь бол ардчилсан оронд гэж яривал аудит шиг хууль хэрэгжүүлэхгүй байвал бас хянах, шалгах, болохгүй байна гэдгийг дуугардаг ийм функц юм байгаа юм л даа төрийн бус гэдэг нь. Тэгэхээр манай энэ хууль нь энэ дээр төрийн бусын тэр чиг үүрэг хэр тусгагдсан бол гэдгийг бас тодруулъя. Тэгээд хууль хэрэгжүүлэхгүй тохиолдолд Зөрчлийн хуулийн ямар заалтаар зохицуулалт байдаг юм. Хууль зөрчвөл яах юм бэ гэдэг асуудлуудыг тодруулъя.

П.Ганзориг: Ажлын хэсэг 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Саранчулуун гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ ер нь сүүлд бас зарчмын зөрүүтэй саналууд дээр энэ хуулийн зохицуулалтууд бас орж ирж байгаа. Ер нь одоо байгаа хууль дээр эрхтэн, эд, эстэй яг адилхан байдлаар одоо цусны донорын үйл ажиллагаа, энэ дээр гарч байгаа алдаа зөрчлүүдийг Эрүүгийн тухай хууль дээр гэдэг байдлаар тусгагдаад явчихсан нь өөрөө бас нэлээн их том асуудлыг дагуулж байсан. Өмнөх хууль дээр бас нийцэхгүй байсан 1 зүйл байгаад байсан. Нөгөө яг зохицуулж байгаа юмнууд маань 2 өөр түвшний зүйл байхад 1 хуулийн санкцаар авч үзсэн нь бас нэлээн том асуудал дагуулж байсан. Тэгэхээр энэ Цусны донорын тухай хууль дээр илүү ийм зөрчлийн шинж чанартай гэдэг байдал руугаа илүү бас шилжиж буюу энэ бол өөрөөр хэлбэл цус сэлбэлттэй холбоотой ямар нэг урвал хүндрэл гарахад гарахад Эрүүгийн хуулиар асуудал орж ирэхээр ийм хүнд санкц байгаад байгаа. Тэгэхээр энэ 2 хууль маань ингэж тус тусдаа болсноор энэ хуулийн зохицуулалтууд ч гэсэн нэлээн бас зохицогдож ингэж явж байгаа ийм зүйл байгаа.

Тэгээд энэ төрийн бус байгууллагууд дээр таны яг саяын асууж байгаа сургалт сурталчилгаа гэдэг тал руугаа бол илүү тусгаад өгчихсөн явж байгаа. Тэгээд тухайлбал, ЦССҮТ маань бол МУЗН гэдэг юм уу, Монголын донорын холбоо, Монголын Гемофилийн Холбоо гэдэг юм уу төрийн бус байгууллагуудтай маш нягт ажилладаг. Яг үндсэн практик дээр. Тэгээд энэ дээрээ бол бид нар энэ байгууллагуудаас саналыг нь аваад, тусгаж өгсөн байгаа. Зүгээр яг хяналт тавих гэдэг юм уу, яг энэ чиглэлийн юмнууд бол бас хууль дээр тийм тодорхой бол тусгагдаагүй байгаа.

П.Ганзориг: Болчихсон уу. Гишүүд асуулт асууж дууслаа.

39.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн даатгал” гэснийг хасаж, “хамт олон, иргэн,” гэсний дараа “олон улсын байгууллагын” гэж нэмж, төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь өөрийн орлого, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдсэн санхүүжилтийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.5-д заасны дагуу зарцуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

40.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсгийг бүхэлд нь тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.6.Цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн “Цусны албаны нэмэгдэл цалингийн хэмжээг” гэснийг “Энэ хуулийн 13.6-д заасан нэмэгдэл олгох журмыг эрүүл мэндийн болон” гэж, мөн хэсгийн “тогтооно” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: 14 дүгээр бүлгийн цусны донортой холбогдолтой тавигдах шаардлага гэж байх шиг байна. Ер нь яах вэ, доноруудаасаа ер нь хэр судалгаа энэ тэр юмнууд ер нь авсан юм. Тэр талаар бас мэдээлэл өгчихвөл зөв байх. Тэгээд хэчнээн хувиас нь ч гэдэг юм уу саналууд авсан юм. Одоо байгаа донорууд бас энэ хуульд оролцсон оролцоог нь та хэд маань хэр хангасан юм гэдэг дээр мэдээлэл өгөөч.

П.Ганзориг: Хууль санаачлагч Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Хуулийн төсөл бичигдэх явцад бол бид бас цусны донор болдог иргэдтэй 3 удаагийн уулзалт хийсэн. Энэ дотор бас хүндэт доноруудтай бас тусгайлан уулзаж, тэдгээрийн санаа бодлуудыг бас энд тусгасан байгаа. Зүгээр ер нь донор болж байгаа хүмүүсийн гол хэлж байгаа зүйл бол бид сайн дураараа өгч байгаа. Ямар нэгэн авлага нэхээгүй. Гэхдээ энийг алдаршуулах чиглэлд бас онцгой анхаараач гэдгийг бас хэлсэн. Нөгөө талаасаа олон нийтэд энэ эрүүл мэндэд өөрөө ямар чухал вэ гэдгийг бас хэлж өгөөч гэж хүссэн. Тухайлах юм бол дундаж насны эрэгтэйчүүдийн цус өтгөрөх, өтгөн байх энэ шинж тэмдэг бол элбэг монголчуудад тохиолддог. Ялангуяа Монголчууд шиг мах, өөх тос их иддэг. Төмрийн агууламж

ихтэй ийм хүмүүст цусны донор болох нь өөрсдийнх нь эрүүл мэндэд хэрэгтэй. Цус шингэлэх, цус өтгөрөлтөөс хамгаалах ийм үйлсэд хэрэгтэй байдаг гэдгийг бас сурталчлах ажиллагааг сайн хийж өгөөч ээ. Бид ийм донор болсноороо эрүүл саруул сайхан байгаа гэдгийг хэлж өгөөсэй гэж гэсэн ийм бас хүсэлтүүдийг хэлж байсан. Тийм учраас бид бас хуульдаа аль болохоор донорыг алдаршуулах үйл явцыг зүгээр нэг засгийн юу гэдэг юм байгууллагын шагнал биш илүү Засгийн газрын хэмжээний том шагнал урамшуулал болгож өгөх талаас энэ хуулийн төсөл суулгаж өгч байсан байгаа.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

43.Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийн “СЭЛБҮҮЛЭГЧ,” гэснийг хасаж, төслийн 14, 17 дугаар зүйлийг нэгтгэн 14 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14 дүгээр зүйл.Цусны донорт тавигдах шаардлага, түүний эрх, үүрэг

14.1.Цусны донор дараах шаардлагыг хангасан байна:

14.1.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ сайн дураар, авлагагүйгээр өгөхийг зөвшөөрсөн байх;

14.1.2.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байх;

14.1.3.эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх.

14.2.Цусны донор дараах эрхтэй:

14.2.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөнтэй холбоотой гарч болзошгүй сөрөг урвалын талаар мэдээлэл, зөвлөгөө авах;

14.2.2.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх ажилд сайн дураар оролцох;

14.2.3.хуульд заасан бусад.

14.3.Цусны донор дараах үүрэгтэй:

14.3.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 18.2.7-д заасан мэдээллийг холбогдох эмнэлгийн мэргэжилтэнд үзүүлэх.

14.3.2.өөрийн эрүүл мэндийн байдлыг асуумжийн дагуу үнэн зөв мэдээлэх;

14.3.3.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгөхийн өмнөх үзлэг, шинжилгээнд хамрагдах;

14.3.4.эмнэлгийн мэргэжилтний өгсөн зөвлөмжийг мөрдөх;

14.3.5.хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 15, 16, 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Донорын эрх, үүрэгтэй холбогдолтой асуудлыг нийлүүлчхэж байгаа юм байна. Хамгаалалттай холбогдолтой асуудал дээр сая Наранбаяр гишүүн бас нэлээн ноцтой юм хэлчхэв үү, үгүй юу. Цусаа өгсөн хүмүүс маань буцаагаад цус авах хэрэгцээтэй тийм тодорхой хэмжээний өвчлөлтэй болоод байна гэдэг тийм мэдээлэл хэлчхэв үү, үгүй юу. Энэ дээр хэрвээ тийм агуулга байгаа бол. Яах вэ, ер нь санаа нь бол цусаа өгснөөр давуу талууд бол байна. Мөн үндсэндээ сөрөг талуудтай холбогдолтой ийм агуулгуудыг нь бас хамгаалсан ийм зүйлүүд энэ дээр юу байна вэ. Эрүүл мэндийн хувьд ч тэр ер нь тодорхой хэмжээнд сөрөг ийм зүйлүүд бас байгаа юу гэдгийг тодруулаад асуучихъя.

П.Ганзориг: Ажлын хэсэг эхлээд хариулах уу. Ажлын хэсгийн 5 номер

Н.Эрдэнэбаяр: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Ер нь цусаа өгөх талаар бол олон улсын зөвлөмж байгаа. Монгол Улс ч гэсэн одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа дүрэм журмын хүрээнд бол энэ үйлсийг сурталчлах ажлууд бол нээлттэй байдаг. Өөрөөр хэлбэл цусаа өгснөөр нэлээн олон талын давуу талууд бол байгаа. Тэгээд олон улсад хийсэн судалгаагаар аваад үзвэл цусаа өгдөг хүмүүс, цусаа өгдөггүй хүмүүсийг харьцуулж үзэхэд зүрх судасны өвчлөл бол Монгол Улсад нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа энэ өвчлөлтүүд дунд хавдрын өвчлөл гэдэг юм уу энэ өвчлөлтүүдийг харьцуулаад аваад үзэхээр цусаа тогтмол хугацаанд өгдөг доноруудын дунд эрс бага байна гэсэн ийм судалгааны үзүүлэлт байдаг. Хүн амыг дагасан олон оронд хийсэн 30-40 жил дагаж хийсэн судалгааны үр дүнгүүд бол ийм эерэг нөлөөллүүд бас байдаг.

Ер нь зүгээр ард иргэдийн дунд цус өгөлтийн талаар буруу ойлголтууд байдаг. Тэгэхээр одоо бид нар энэ хууль шинэчлэгдэж гарснаар энэ дээр нэлээн их түлхэц өгч, ард иргэдийн дунд байгаа энэ буруу ойлголтуудыг засахад бас нэлээн их хувь нэмэртэй болно гэж ингэж харж байгаа. Зарим нэг хийсэн судалгаануудаар аваад үзвэл тогтоол хугацаанд цусаа өгөхөд 5-8 удаа өгөлтийн дараа цус багасах гэдэг юм уу ийм зүйлүүд бол ажиглагддаг. Энэ бол нөгөө хүний бие махбодын өөрийн физиологийн онцлогтой холбоотойгоор ийм зүйлүүд ажиглагдаад, энэ үеэс хойш бол ер нь тогтмол хугацаанд цусаа өгөхөд ер нь цус төлжилтийн үйл ажиллагаа ердийн цус өгдөг хүнээсээ бол илүү байдаг. Түрүүн Чинбүрэн гишүүн бас хэлж байсан. Энэ цус шингэрэх гэдэг юм уу маш эерэг ийм нөхцөл байдлууд бол их байдаг гэдгийг судалгаагаар тогтоочихсон. Монгол Улсад ч хийсэн ийм судалгааны ажлууд бас байгаа.

П.Ганзориг: Болчихсон уу. Хууль санаачлагчаас Чинбүрэн гишүүн нэмэлтээр хариулъя.

Ж.Чинбүрэн: Сая бол нөгөө сөрөг нөлөө байж болох уу гэдгийг Ганхүлэг гишүүн асууж байна. Тэгэхээр олон удаа цус өгснөөрөө цус багадах шинж тэмдэг байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ яагаад бид нөгөө эмчийн үзлэгээр орно гэж хэлээд байгаа юм гэхээр жишээлэх юм бол ходоодоо тайруулчихсан хүн байх юм бол витамин В12-ын дутагдалтай байдаг учраас цусаа нөхөж чаддаггүй. Тэгээд цусны донор болоход бол удаан хугацаанд цус нь нөхөгдөх ийм аюултай байдаг гэх мэтчилнээр заавал нөгөө эмчийн үзлэгээр ордгийн давуу тал нь таны цус төлжих процесс хэр хурдан байх вэ гэдгийг бас тодорхойлж байгаа зүйл байхгүй юу. Тийм

учраас эрсдэл бараг байхгүй гэж болно. Тухайлах юм бол манай энэ эрүүл мэндийн байгуулга цусыг нь авчхаад араас нь калоритой хоол өгнө, биеийг нь хэвийн байдалд оруулна. Цус авсны дараагаар бас толгой эргэх, чих шуугих иймэрхүү шинж тэмдэг, эсвэл айж сандарсан байхыг үгүйсгэхгүй. Иймэрхүү шинж тэмдгүүд л гарахаас бүр тийм ноцтой зүйл бол гарч байсан түүхийг бол мэдэхгүй байна. Урт хугацаандаа бол сая хэллээ. Эрүүл мэндийн тэр нөхцөл байдлаас нь хамаараад хэнээс авах вэ гэдэг бол их чухал. Эрүүл мэндийн сайн талаасаа бол их байгаа шүү. Сайн талаасаа бол их байгаа. Тийм учраас бидэнд өнөөдөр энэ Байнгын хороог бас сонсож байгаа иргэддээ хүртэл зориулж хэлэхэд бол ер нь дундаж насны эрэгтэйчүүд бид цусанд холестерин хэмжээ ихтэй, тэгээд хүнд металлын илүүдэлтэй, төмрийн илүүдэлтэй гэх мэтчилний ийм хүмүүс байхад бол цусаа өгөхөд илүү эрүүл мэндэд нь ач тустай. Үүний цаана бол бүр сайн ач тусыг нь ярих юм бол хүний амь нас аварч байгаа. Би бол өөрөө мэдэж эмчээр 29 жил ажиллаж байна. Хагалгааны ширээн дээр хагалгаа хийж байгаад цус байхгүй сандарч байсан үе байгаа шүү дээ. Хүний амь насыг алдах гээд байж байсан үе байдаг. Харин одоо сүүлийн үед бол маш сайн чамбай болсон. Энэ тогтолцоо сайжирсан. Дээрээс нь хагалгааны ур чадварууд сайжирсан. Зөвхөн элэг шилжүүлэн суулгах хагалгаа хийхэд 5-8 литр цус хэвийн хагалгааны явцад хийнэ шүү дээ.

П.Ганзориг: Түрүүчийн Ганхүлэг гишүүний асуулт Наранбаяр гишүүний түрүүний асуулттай холбоотой учраас Наранбаяр гишүүн товч хариулчхаад, тэгээд тодруулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Ийм боломж олгосон хурал даргалагч, Байнгын хорооны даргадаа талархал илэрхийлье. Тэгэхээр Ганхүлэг гишүүн сая би буруу ойлгосон шиг байна. Ер нь бол донорын хуулийг би дэмжиж байгаа. Ялангуяа донорыг бол хөхиүлэн дэмжих нь төрийн бодлого байх ёстой гэсэн байр суурьтай байдаг. Миний ээж, аав 2 хоёулаа эмч хүмүүс. Манай аав бол өөрөө 800 гаран хагалгаа хийсэн, АУИС-д багшилсан ийм хүн. Би эмчийн гэр бүлд өгссөн учраас энэ донорын ач холбогдлыг маш сайн ойлгоно. Ийм учраас ялангуяа миний хэлсэн санаа бол энэ донорыг дэмжиж хөхиүлэн дэмжих мөн донорын тоог нэмээд ингээд явах нь бол эрүүл аж төрөх ёсонд хэрэгтэй юм.

2 дугаарт нь энэ донорыг дэмжээд явах юм бол бас нийгмийн дундын баялаг бас нэмэгдэх юм. Бусдын төлөө ажил шүү дээ. Тэгээд сая бас Чинбүрэн эмч хэлж байна. Энэ мэргэжлийнхэн ярьж байна. Ер нь бол эрүүл мэндэд сөрөг нөлөө бараг байхгүй гэж хэлж байна. Дээр нь нэмээд бас донороор ингээд өгөөд байгаа хүн өөрсдөө их эрүүл мэнддээ анхаардаг, цусаа өгдөг хүмүүс элдэв халдварт өвчин тусахгүйн төлөө өөрөө өөрийгөө биеэ их зөв, сайн авч явдаг ийм хүмүүс байдаг. Богино хугацаандаа цусны дутагдалд мэдээж орох байх. 2, 3 хоног. Тэрний дараа бол ерөөсөө цусаа өгдөг хүмүүс би донор хүмүүстэй уулзаад явж байхад өгөхгүй удчихаараа жоохон бие их сонин байна гэж ярьдаг л ийм л байдаг. Тэгэхээр энэ цусаа бусдад өгч ингэж буянтай үйлс хийж байгаа ийм хүмүүс бол ардын баатрууд ийм мундаг хүмүүс. Ийм учраас энэ хуулийн төслийг бол хүчтэй дэмжиж байгаа. Тэгээд нийгмийн дунд ийм дундын өмч, баялгийг бий болгож байгаа ийм хүмүүс шүү л гэдгийг хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Буруу ойлгосон бол бас хүлцэл өчье. Донорын эрхийг хамгаалах чиглэлийн тодорхой ямар заалт байна вэ л гэж асуугаад байгаа юм. Хэрвээ ямар

нэгэн эрсдэл үүслээ гэж бодоход яаж хамгаалах вэ. Тэгээд тэр нь энэ хууль дээр яаж туссан бэ гэдгийг нь тодорхой. Ерөнхий агуулгыг нь бол ойлгож байгаа. Дэмжиж байгаа. Тийм тодорхой заалтууд байна уу. Эрх, үүргийн тухай ярьж байгаа учраас.

П.Ганзориг: Хууль санаачлагч Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Донорын эрх, үүрэг дотор бас нэлээн чухал зүйл бол консент форум буюу зөвшөөрлийн хуудас гээд байгаа. Тэгэхээр ямар сөрөг үр дагаврууд байж болох вэ, энэ нөгөө авлагагүй өглөг учраас сайн дураараа өгч байгаа гарч болох эрсдэлийг бүрэн тайлбарлаж өгсөн байх ёстой. Тэрийг зөвшөөрөөд байна гэдэг нь л өөрөө цусаа өгөх эрхийг нээж өгч байгаа. Мэдээж өнөөдөр бол энэ аюулгүй болчихсон юм шүү. Жишээлбэл, дандаа цус авахдаа 1 удаагийн хэрэгслүүдээр авна. Ямар нэгэн халдвар хамгааллын дэглэм алдах тийм нөхцөл байхгүй. Нөгөө талаасаа тухайн хүний цусны бүтээгдэхүүнийг авах бүрдээ шинжилгээ хийж байгаа. Лаборатори, маш хүчтэй лаборатори цусны төв дээр ажилладаг юм шүү дээ. Тэр дотор байгаа бүх эрсдэлүүдийг нь тооцдог. Эсрэгээр нөгөө хүнийхээ эрүүл мэндэд байгаа сөрөг зүйл юу байгааг нь бүр илрүүлж өгөх ийм талтай. Тэгэхээр бол энэ дээр донорын үүрэг гэдэг дээр бид гол чухал зүйл яаж байгаа бол калоритой хоолоор хангаж өгөх, дээрээс нь ажлаасаа чөлөө авахад цалинтай чөлөө авах энэ тэр гэсэн ийм урамшууллын нөхцөлүүдийг илүү суулгаж өгөхөөр хуулийн төслөө би бол бичсэн. Тэгэхээр энэ дээр үүрэг, хариуцлагын хувьд бол ерөөсөө ийм л зүйл байгаа. Тэгэхээр айхтар тийм ноцтой зүйл гардаггүй гэдэг санааг дахин хэлье.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

44.Төслийн 15, 16, 18 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

15.1.Иргэний амийг аврах, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэхдээ сэлбүүлэгч эрх зүйн бүрэн чадамжтай бол өөрөөс нь, хүүхэд болон эрх зүйн бүрэн чадамжгүй сэлбүүлэгчийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бичгээр зөвшөөрөл авсан байна.

15.2.Энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авахдаа цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх шаардлага, сэлбэх явцад гарах үр дагаврын талаар сэлбүүлэгчид урьдчилан танилцуулсан байна.

15.3.Амь тэнссэн үед, эсхүл энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авах боломжгүй тохиолдолд холбогдох журам, зааврыг баримтлан цус цусан бүтээгдэхүүнийг сэлбэнэ.

15.4.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

15.5.Хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 64 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Хосбаяр гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: 19 дүгээр зүйл дээр хууль санаачлагчдын зүгээс ямар зүйл оруулсан байгаа вэ гэхээр яг энэ цусны донор энэ цусны бүлэг гэдэг юм уу яг энэ сэдвээр хүүхдүүдэд сургуульд сурахаас нь авхуулаад мэдээлэл, мэдлэг өгөх тухай заалтууд байсан юм. Тэгэхээр энэ ойлголт ач холбогдлыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулаад бас тодорхой мэдээ, мэдээлэл өгдөг байя гэсэн ийм зүйл заалтыг оруулсан. Яах вэ, ажлын хэсгийн хүрээнд бол яг энэ сургалтын хөтөлбөрт оруулах нь буруу юм гэж үзсэн учраас энэ заалтыг бол хассан байна. Гэхдээ ер нь бол яг нийтэд нийтлэг энэ мэдээ, мэдээлэл ямар хомс байдаг вэ гэдгийг Улсын Их Хурлын гишүүдийн энэ асуултаас бас харж болно гэдгийг би та бүхэндээ хэлмээр байна. Ер нь бол цусны донор гэдэг чинь сар бүрийн 3-ны өдөр бол тодорхой арга хэмжээ зохион байгуулаад, нийтэд уриалаад, байгууллагуудаар очоод ийм тодорхой ажлууд явагддаг. Гэхдээ нөгөө хэдэн төрлийн ер нь цус байдаг юм. Таны 1 удаа өгсөн цус чинь 3 хүний амийг аварна гэж бид нар ярьдаг. Гэвч яг цагаа тулах юм бол 3 хүний цус ч 1 хүний амийг аврахад дутдаг байхгүй юу. Тэгэхээр нэн ялангуяа хэчнээн төрлийн цус байдаг юм. Ховор төрлийн цустай хүмүүс нэн ялангуяа эдгээр цусны хэрэгцээ шаардлага бол маш өндөр байдаг. 2 дугаар бүлгийн цустай хүмүүсийн цус бол нэлээд түгээмэл байдаг гэх мэтчилэн бусад улс орнууд бол бүр ийм гар утасны аппликэйшнээр дамжуулаад доноруудаа хүртэл түүндээ өөрсдөө ороод яг таны яг энд чинь яг ийм тохиолдол гарсан байна. Яаралтай ийм бүлгийн цус хэрэгтэй байна гэсэн дохио хүртэл ирдэг байхгүй юу. Тэгээд шуурхай очиж бас цусаа хандивлаж өгдөг ийм аппликэйшнууд хүртэл байдаг.

Цусыг бас өгөхдөө зүгээр шууд би өгмөөр байна гээд л оччихдог юм бас биш. Наанаа бас бэлтгэлтэй байх ёстой. Эрэгтэй хүн сард 1 удаа өгнө. Эмэгтэй хүн бол 2 сард 1 удаа өгнө. Мөн түүнчлэн 10 хоног ямар нэгэн эм хэрэглээгүй байна, дор хаяж 1-2 хоног архи, согтууруулах ундаа хэрэглээгүй байна. Өөхтэй тостой хоол идээгүй байна. Ямар нэгэн суурь өвчлөлгүй байна гэх мэтчилэн маш олон шалгуур үзүүлэлтүүд бас тавигддаг юм. Тийм учраас наад захын ердийн ойлголтыг уг нь нийтэд боловсролын системээр дамжуулаад өгье гэсэн ийм санаа л байсан юм. Гэхдээ яах вэ ингээд цааш цаашлаад энэ хууль өөрөө тусгайлж гарч байгаа нь бас нийтэд тодорхой хэмжээний бага зэрэг ч гэсэн мэдээлэл өгөх байх гэсэн үүднээс энэхүү саналыг нь дэмжээд явахаас өөр аргагүй байна.

П.Ганзориг: Үг хэллээ. Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Манай Их Хурлын гишүүд дотор бас цусны донор хүмүүс нэлээд хэд байдаг юм байна лээ. Би бас уулзаж байсан. Би өөрөө бас цусаа өгдөг хүн. Тэгээд 1 удаа очоод тэр 450 гр цус өгөхөд ч бас эхлээд бол амаргүй л байдаг юм байна лээ. Тэгээд одоо бол сурчихсан. Тэгээд энэ цусан бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой асуудлыг асуух гээд байгаа юм. Би өмнө нь 1 дүгээр эмнэлэг дээр цус цуглуулах төв дээр өгдөг байсан. Одоо сүүлд болохоор 2 дугаар эмнэлгийн хашаанд байгаа цус цуглуулах төв дээр цусаа өгч байгаа. Тэгэнгүүт тэндээс гэмтлийн эмнэлэг ч гэдэг юм уу, бусад эмнэлэг рүү дроноор цус тээвэрлэж байгаа ийм зүйл харагдаж байсан. Тэгэхээр ер нь эмнэлгийн байгууллагууд хот дотор ч яах вэ дроноор зөөчхөж болж байх шиг байна. Энэ нь яг тэр агаарын нисэхийн хууль бас орж ирж байгаа. Үүнтэй бас холбох юм байгаа юу.

2 дугаарт нь аймгууд дээр цус цуглуулах төвүүд байгаа. Тэгэхээр магадгүй аймагт аюул осол болоод, маш их цус хэрэг бол өөр ямар нөхцөл байдлаар тэнд цус хүргэх вэ. Ер нь тийм гарц гаргалгаа байдаг юм уу. Энэ хуулийн 22 дугаар зүйл дээр цус цуглуулах, шинжлэх боловсруулах зориулалтын тусгай тоноглогсон тээврийн хэрэгсэл ашиглана л гэж байна л даа. Одоо чинь бол бас нөгөө агаарын тээвэр, дрон энэ тэр гээд зөндөө юмнууд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ер нь илүү их тодотгож өгөх тийм заалт байх уу. Тэгээд ер нь бол нөгөө цус өгөхийн сайн тал, ач тусыг бол зөндөө ярьчихсан учраас одоо илүүц байх. Ер нь бол бас мэдээж сайн дурын авлагагүй ийм өглөг гэж ярьдаг учраас энэ маань бол ер нь хүн арддаа соён гэгээрүүлэх бас зөв талыг нь таньж ярих ажил бол маш чухал гэдгийг бас энэ хуулийн төсөл дээр анхаарах ёстой байх гэж ингэж бодож байна. Тийм учраас энэ тээвэрлэлт, хадгалалттай холбоотой асуудал дээр тодорхой мэдээлэл өгөөч ээ гэж.

П.Ганзориг: Ажлын хэсэг 5 номер хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Үнэхээр цусаа тогтмол хугацаанд өгдөг Их Хурлын гишүүд нэлээн байдаг талаар манай яг энд ажилладаг хүмүүс маань бас мэдээлэл өгч байна. Тэгээд ер нь хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой асуудлууд дээр бас нэлээн нарийн шаардлагууд тавигддаг. Сийвэнгийн бүтээгдэхүүн байна уу, улаан эсийн бүтээгдэхүүн байна уу, ялтасны бүтээгдэхүүн байна уу гэдгээр хадгалах нөхцөлүүд нь тус тусдаа өөр. Ингээд зориулалтын ийм бас зүйлүүд дээр тодорхой хугацаагаар хадгалагддаг. Тухайлбал, сийвэнгийн бүтээгдэхүүнийг бид нар урт хугацаанд хадгалах мөн алс тээвэрлэх бүрэн боломжууд байдаг. Улаан эсийн бүтээгдэхүүн болон ялтасны бүтээгдэхүүн дээр бол тодорхой хязгаарлалтууд бас байдаг байгаа.

Сүүлийн үед Улаанбаатар хотын энэ түгжрэлийн асуудалтай холбоотой дронуор цус тээвэрлэх асуудлыг 2020 оноос эхлээд явсан. Иргэний нисэхийн дүрэм дээр бол хориотой байсан асуудлууд нь бол дроны төслүүд 2022 оноос хэрэгжиж байгаа төсөлтэй холбоотой бас шинэчлэгдээд энэ боломжууд нээгдэж байгаа. Өөрөөр хэлбэл зөвхөн цус тээвэрлэх биш бусад ойр зуурын тээвэрлэлтүүдийг дрон ашиглаж хийх энэ боломжууд бас Монгол Улсад бүрдэж байгаагаараа энэ дээр бол цусыг тээвэрлэх нь бол өөрөө анхдагч болсноороо бас ийм онцлогтой зүйл байж байгаа. Хамгийн гол нь одоо яг бид нарын байгаа жишээ нь Баян-Өлгий аймагт цус хэрэгтэй боллоо гэвэл бид нар онгоцоор тусгай ийм сав баглаа боодлыг нь бүрдүүлээд, өөрөөр хэлбэл био бүтээгдэхүүн гэдэг утгаар нь 3 давхар сав баглаа боодлоор хийгээд тодорхой албан бичгээр хандаж, онгоцоор тээвэрлэж байгаа. Галт тэргээр тээвэрлэх, автомашинаар тээвэрлэх гээд энэ бүтээгдэхүүний онцлогоос хамаараад энэ зүйлүүд байдаг. Гэхдээ яг хууль дээр таны асуусны дагуу вагоноор гэдэг юм уу, агаарын тээвэр, онгоцоор гэдэг байдлаар бас тусгагдаагүй байгаа. Тэгэхээр энийг бид нар ажлын хэсэг дээрээ ярилцаад, ер нь одоо бол журмаар яваад байгаа. Хэрвээ энийг шаардлагатай гэвэл хууль дээрээ нэмээд оруулчих боломжтой гэж ингэж харж байна.

П.Ганзориг: Ажлын хэсгийн ахлагч Баясгалан гишүүн нэмж мэдээлэл өгье.

Ж.Баясгалан: Тэгээд бас энэ дээр нэмэлтээр мэдээлэл өгөхөд зөвхөн цусны төв дээр цус цуглуулдаггүй. Монгол Улсын хэмжээнд цусны салбар төв бол 21 аймагт байгаа. Мөн алслагдсан Багануур, Налайх дүүрэг, 4 сумд байдаг. Хархорин, Мандал, Тосонцэнгэл, Замын-Үүд гээд. Тэгээд энэ байгууллагуудад цус сэлбэх, цус хуримтлуулах, цус төвлөрүүлж хадгалдаг байгаа. Тэгээд сая ажлын хэсэг маань дахиад хэлье. Ажлын хэсэг бол сая аймгуудаар яваад, яг энэ цусны хадгалалт

болон цусны төвүүдтэй бол танилцсан. Тэнд байгаа ажилчдын нөхцөл байдал болоод хадгалж байгаа бүтээгдэхүүнүүдийг бол бүгдийг нь үзсэн. Түрүүн тэгээд бас ярьж байсан. Энд байгаа ажиллагсдын нөгөө хүнд нөхцөл гээд бид нар яриад байсан. Тэрний хувьд бол дандаа эмэгтэйчүүд голдуу ажилладаг. Тэгээд цус маань өөрөө онцгой нөхцөлд хадгалдаг цус, цусан бүтээгдэхүүн маань. Тэгээд зарим тохиолдолд 68 градусын хүйтэн хөргөгч рүү орох, хадгалах тэрнээс бүтээгдэхүүнээ авах юмнууд гардаг учраас нөгөө халуун, хүйтэн хоршиж тэр хүмүүсийн эрүүл мэндэд бол бас маш их хүндрэлтэй байдаг юм байна лээ. Тэгээд энд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд бол бас эрүүл мэндийнхээ салбарт цусны төвөөсөө гарч өөр салбар луу орох гээд байдаг учраас бид нар бас дэмжиж явах нь зүйтэй гэж бас мэдээллийн чанартай бас хэлье. 21 аймаг, 4 сум, алслагдсан 2 дүүрэгт бас байдаг байгаа шүү.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

45.Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлийг нэгтгэн 19 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх

19.1.Монголын улаан загалмай нийгэмлэг болон төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага болон албан тушаалтан, иргэн нь цусны донорыг элсүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаанд сайн дурын ажилтныг оролцуулж болно.

19.4.Цусны донорыг “Цусны хүндэт донор” цол тэмдгээр дараах шалгуурын дагуу шагнаж, алдаршуулна:

19.4.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш өгсөн;

19.4.2.цусаа 35 болон түүнээс дээш өгсөн;

19.4.3.ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш өгсөн.

19.5.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

19.6.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

19.7.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд Засгийн газраас тогтоосон сувиллын жишиг үнийн дагуу жилд нэг удаа сувилуулна.

19.8.Энэ хуулийн 19.7-д заасан дэмжлэгийг Ахмад настны тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан дэмжлэгтэй давхардуулан олгохгүй.

19.9.Энэ хуулийн 19.7-д заасан дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа жишиг үнийн дагуу сувилуулах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.10.“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүндэт донор”, “Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүндэт донор” цол тэмдэгтэй иргэнд энэ хуулийн 19.7-д заасан дэмжлэг хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад нийт 25 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 56 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны ирцэд орсон гишүүдийг бас танхимд орж ирэхийг урьж байна.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Ариунзаяа гишүүн дарчих уу. Наанаа дарна шүү дээ. Нэр нь орж ирэхгүй байгаад байна. Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүн асуулт асууя. Байж байгаарай. Ариунзаяа гишүүн юм шиг байна ирцээрээ. Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Ирцээрээ дугаар номер нэг Ариунзаяа асуулт асууя гэж. Энэ нийтийн тээврээр одоо угаасаа үнэ төлбөргүй зорчдог байхгүй юу хүндэт донорууд. Тэгээд нэн ялангуяа картаа уншуулахад автобусанд чинь нөгөө баярлалаа гэж уншдаг шүү дээ. Хүндэт доноруудыг болохоор хүндэт донор гэж уншдаг байхгүй юу. Тэгээд одоо мөрдөгдөж байгаа заалтыг уг нь энэ хуульдаа дахиад яг тэр хэвээр нь л үлдээсэн юм. Тэгээд энэ маань ямар учраас хасагдаад явчлав. Би нөгөө сургалтыг л бодож байсан. Энэ чинь нөгөө 3 зүйлийг нийлүүлэнгүүтээ одоо мөрдөгдөж байгаа энэ заалт яачихсан байх юм. Хасагдчихсан байгаад байх юм. Угаасаа л одоо хүчин төгөлдөр явж байгаа л даа. Хүндэт донорууд орон нутаг нийслэлд үнэ төлбөргүй буюу нийтийн тээврээр зорчдог. Тэгээд энэ чинь цөөхөн хүмүүс байгаад байдаг. Угаасаа 50 ба түүнээс дээш удаа цусаа хандивлаж байгаа энэ хүмүүс чинь л хүндэт донор болж байгаа шүү дээ. Тэрнээс биш над шиг 2 ба түүнээс дээш өгсөн бол зүгээр л Донор гэдэг юм уу, давтамжит донор хуулиар юу гэсэн байлаа. Тэгээд ийм байгаад байгаа. Тэгэхээр энэ асуудлыг тодруулж өгөөч. Энэ яагаад одоо байгаа нөхцөл байдлыг дордуулсан л юм болчих шиг болох юм. Би сая анзаарахад.

П.Ганзориг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 5 номер.

Н.Эрдэнэбаяр: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Нийтийн тээврээр яг хүндэт донорууд буюу нөгөө 30 удаа бүхэл цусаа, 35-аас дээш удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн донорууд бол яг автобусанд бол үнэ төлбөргүй зорчиж байгаа. Энэ зохицуулалтууд бол Цусны төв, Улаанбаатар Смарт карт компани, тэгээд Нийслэлийн нийтийн тээврийн газартай ийм гуравласан гэрээ байгуулж, Улаан загалмайн нийгэмлэгтэй ийм гэрээнүүд байгуулагдсаны үндсэн дээр зохицуулалт нь бол явж байгаа. Тэгэхдээ энэ нөгөө улс даяар бас үйлчилдэггүй. Зөвхөн нийслэлийн хүрээнд ингэж бас яг энэ хөнгөлөлт, үйлчилгээнүүд явагдаж байгаа. Тэгэхээр энэ байдлаараа зохицуулах боломжтой гэдэг ийм саналыг өгсний дагуу энэ дээр яг тухайлан зааж өгөөгүй байгаа энэ заалт дээр. Одоо журмаар зохицуулаад явж байгаа л гэсэн үг.

П.Ганзориг: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Яах вэ нөгөө нийслэлээс дэмжээгүй санал ирсэн учраас үүнийг хассан гэсэн мэдээллийг сая авлаа л даа. Тэгэхээр нөгөө хот хоорондын тээврийн асуудлыг огт яриагүй шүү дээ. Нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл буюу таксинаас бусад орон нутгийн харьяалал харгалзахгүй тэндээ л томоохон аймгийн төв байлаа гэхэд чинь Дархан, Орхон хаана байдаг юм. Тэнд нийтийн тээвэр явж байгаа бол тэндээ бас үйлчлүүлэх л ийм асуудал шүү дээ. Тэгээд энэ хүндэт доноруудаа одоогийн байдлаар автобусан дотор явж байгаа хүн болгон хүндэт донор гэж хэлэхэд уг нь бүгдээрээ хараад бас тэр чинь 1 ёсны алдаршуулж байгаа нэг асуудал мөн байхгүй. Тэгээд энийг маань л битгий болиулж өгөөч ээ л гэж би хүсэх гээд байгаа юм. Энэ чинь ядаж ингэснээр нийтийн тээвэр маань дампуурчихгүй байлгүй дээ. Цөөхөн хэдэн хүн байгаа шүү дээ гэсэн л ийм санаатай байна. Тэгэхээр энийг найруулгаар юм уу, эсвэл битгий энэ нь байхгүй болоосой гэдгийг л баталгаажуулах ийм заалт хэрэгтэй шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

П.Ганзориг: Ариунзаяа гишүүний хэлээд байгаа санал чухал шүү. Тэгээд энэ чинь тэр нийтийн тээврийн орлогод тэглээ их нөлөөлөхгүй шүү дээ. Тэгээд энэ бодлогын ийм том юм явж байхад энэ байдаг зүйлийг нь бас хасаж болохгүй л дээ. Ганхүлэг гишүүн асуулт асуучихъя.

М.Ганхүлэг: Сая нэгтгээд явчихсан учраас энэ 19.4 дээр асуух гэж байгаад үлдчихлээ. Энэ Цусны донорын хуулийг дэмжиж байгаа. Эрх зүйн байдал бас битгий буураасай гэсэн ийм бодолтой байгаа. Тэгэхээр саяын бас Ариунзаяа гишүүний саналтай санал нэг байна. Дахиад 1 нь болохоор хуучин бол 32 байсан байх, 35 байсан уу. 35 удаагийн үндсэндээ хатгуулаад, хүндэт донор болох болзлоо хангадаг байсан бол энэ байдал бас эрх зүйн байдлын хувьд ч байдаг юм уу, тооны хувьд бол нэмэлт болоод орж ирж байна л даа. Эрэгтэй хүн бол 2 сар тутам байгаа. Эмэгтэй хүн бол 3 сар тутамд үндсэндээ цусаа 35 удаагаас дээш удаа өгч байж гэхээр эрэгтэй хүний хувьд бол 5,8 жил тасралтгүй өгөх нь байна. 2 сар тутам. Эмэгтэй хүний хувьд бол 8,7 жил тасралтгүй өгөх нь байна. Тэгэхээр энэ олон улсын жишиг нь ийм байдаг юм уу. Хуучин бол тэр сийвэнг нь тоолоод, бусад зүйлүүдийг нь ч гэсэндээ тоолоод илүү богино хугацаанд хүндэт донор болгох боломжтой байсныг бид нар илүү урт хугацаатай болгож оруулж ирж байна. Тэгэхээр дордож байгаа юм шиг санагдаж байна. Тэгээд үүний шалтгаан юу юм бэ. Хүндэт донор маань ихэдчихээд байгаа юм уу. Энэ олон хүмүүсийг бид нар хүндэт донор болгож, тэмдэг өгөхөд ингэж бас шалгуураа нэмэх ийм шаардлага бас байгаа юм уу гэдгийг асууя. Бусад олон улсын жишиг нь бас ямар байдаг юм гэдгийг тодруулъя. Түүнтэй нийцүүлж барьж байгаа зүйлүүд бас байгаа юм уу гэдгийг тодруулъя.

П.Ганзориг: Ажлын хэсгээс 8 номер. Цус хэлбэр судлалын үндэсний төвийн Тусламж, үйлчилгээний чанарын аюулгүй байдлын албаны дарга Тунгалагтуяа байна. Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Цусны хүндэт донорын цол тэмдгийн шалгуурыг яагаад ингээд одоо байгаа нөхцөлөөс дордуулсан юм бэ гэдэг байдлаар асууж байна. Бид нар энэ дээр бол цусны хүндэт донор цол тэмдгийг Засгийн газрын шагнал болгож байгаатай холбоотой шалгуурыг олон улсын жишигт нийцүүлээд гаргаж өгсөн байгаа. Олон улсдаа бол цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг 50-аас дээш удаа өгч байж бүхэл цусаа 50-аас дээш өгч байж хүндэт донор цол олгодог байгаа. Олон улсдаа. Тэгэхэд бид нар бүхэл цусаа 35 болон түүнээс дээш, цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ бол 50 болон түүнээс дээш гэж тодорхойлж өгсөн байгаа. Тэгэхээр ер нь бол яг олон улсын жишигт нийцүүлж энийг гаргаж өгсөн гэсэн үг.

П.Ганзориг: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Яг аль аль улсад ямар байгаа гэдгийг нь дэлгэрүүлээд чуулган дээр би бас асууна. 7, 8 жил бас тасралтгүй өгнө гэдэг тийм амар бас биш шүү дээ. Тэгээд нөгөө талдаа бид нар айхтар тийм их мөнгө цаас ч байдаг юм уу, айхтар дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм бол байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ бол хүндэт донор болоход нь хэтэрхий бас хэдүүлээ энэ шалгуурыг нь өндөрсгөөд байх нь бас зохимжтой юу, үгүй юу. Шаардлагатай бол тодорхой зэрэглэл бас байх ёстой юу, үгүй юу. Дотор нь бас жоохон ангилаад хүмүүсээ ер нь урамшуулах тиймэрхүү зүйлүүд нь бас бид нарын гол хөшүүрэг юм бол энэ дээр нь бас жоохон нээлттэй уян хатан байх нь бол зөв байх.

Тэгээд тэр Засгийн газрын шагналд тодорхойлж байгаа талаараа дахиад жоохон дэлгэрүүлээч. Тэр ямар шагнал болоод яаж олгохоор байгаа юм.

П.Ганзориг: Ажлын хэсэг 5 номерын микрофон.

Н.Эрдэнэбаяр: Ганхүлэг гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Ер нь бол одоо байгаа хүндэт донор гэсэн шагнал байгаа. Энийг МУЗН-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр олгодог. 35 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донор мөн 30-аас дээш удаа бүх л цусаа гэж байгаа юм. Ийм донорууд дээр бол МУЗН-ийн хүндэт донор гэсэн шагналыг өгч байгаа. Цусны донорын тухай хууль шинэчлэгдэж байгаатай холбоотойгоор яг энэ донорын нэр томъёо маань бас өөрчлөгдөж байгаа. Цусны хүндэт донор гэдэг ийм нэр томъёогоор явж байгаа. Энийг Эрүүл мэндийн сайдын хэмжээнд олгох буюу Засгийн газрын шагнал Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан гэдэгтэй яг дүйцэж цусны хүндэт донор гэдэг ийм байдлаар томъёолж энэ хуулийн төсөл дээр орж ирсэн. Энэ 50 удаа гэдэг бол эрэгтэй хүн 2 сард, эмэгтэй хүн 3 сард 1 удаа гэдгээрээ тооцвол таны гаргасан тооцоолол яг зөв байгаа. Гэхдээ өнөөдөр донор бол нөгөө бүхэл цусаа өгөөд, тэгээд 4 удаа сийвэнгээ өгөөд гээд ингээд ийм схемүүдээр бид нар цус авдаг. Тэгэхээр энэ байдлаар аваад үзвэл жилд 12-13 удаа өгөх боломжтой. Ингээд тооцвол ер нь 4 жилийн дотор энэ цусны хүндэт донор гэсэн энэ цол тэмдгийг авах бас бүрэн боломжууд байж байгаа. Нөгөө талаас энэ бол нөгөө цусаа байнга, тогтмол хугацаанд өгөх. Энэ нь цаад утгаараа бол цусны аюулгүй байдлыг хангахад бол чухал нөлөөтэй гэсэн юмнууд байж байгаа. Тэгээд бид нар бас танд бас ямар ямар улсуудад хэдэн өгөлтүүдээр цусны хүндэт донор цол тэмдгийг өгдөг вэ гэдэг мэдээллийг бас дэлгэрэнгүй өгье.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

46.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тээвэрлэх үйл ажиллагааг” гэсний дараа “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 15.1.12-т заасан” гэж нэмж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.12-т заасан эрүүл мэндийн байгууллага нь цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах зориулалтаар тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглан энэ хуулийн 22.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

22.3.нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүйгээр зорчих.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 56 хувиар дэмжигдлээ.

47.Төслийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “гүйцэтгэж болно.” гэснийг “гүйцэтгэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.4, 22.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, санал 56 хувиар дэмжигдлээ.

48.Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “зүйлийн 22.5 дахь хэсэгт заасан” гэснийг “хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн” гэж, мөн заалтын “цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан” гэсний дараах “тусгай мэргэжлийн төвд” гэснийг “эрүүл мэндийн байгууллагад” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, 56 хувиар санал дэмжигдлээ.

49.Төслийн 22 дугаар зүйлийн 22.7, 22.8 дахь хэсгийг нэгтгэн 22.7 дахь хэсэг болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.7.Цус, цусан бүтээгдэхүүнийг Эрүүл мэндийн тухай хуулийн 37.3-т заасан журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гишүүн гаргах гишүүд байна уу. Алга байна.

50.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийн “биобэлдмэлийг” гэснийг “цусны бэлдмэлийг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “байдлын хувьд баталгаажсан” гэснийг “байдлыг хангасан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 64 хувиар дэмжигдлээ.

Төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

51.Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “онцгой” гэснийг “ноцтой” гэж өөрчилж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах ажлыг улсын хэмжээнд гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба, тодорхой нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед орон нутгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 64 хувиар дэмжигдлээ.

52.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.3, 24.4, 24.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 64 хувиар дэмжигдлээ.

53.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “24.1, 24.3, 24.5-д заасантай” гэснийг “24.1-д заасан зохион байгуулалттай” гэж, мөн хэсгийн “холбоотой зардлыг” гэсний дараах “Засгийн газрын нөөц сангаас” гэснийг “Гамшгийн тухай хуулийн 51.4-т заасны дагуу” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, санал 64 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

54.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 25.2 хэсгийн “сангийн” гэснийг “сан байгуулах, ажиллах” гэж өөрчилж, мөн хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараах “асуудал эрхэлсэн” гэснийг хасах:

“25.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор цусны донорын мэдээллийн сантай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 14 гишүүн дэмжиж, 56 хувиар санал дэмжигдлээ.

55.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3, 25.4, 25.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 26 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Хосбаяр гишүүнээр тасаллаа. Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Түрүүний нөгөө урамшуулал, болзолтой холбоотой хэсэг дээр асуух гэж байгаад бас өнгөрчихлөө. Тэгээд сая бас юм үзлээ. Олон улсад чинь бас уг нь жишиг нь хүрэл донор, мөнгөн донор, алтан донор гээд байна л даа. Тэгэхээр энэ жишгийг бас нэвтрүүлж болохгүй юу. Заавал яг хатуу 50 гэсэн тоо тавиад, тэгээд түрүүн бас Засгийн газрын шагнал гээд нэг ярьчих шиг болох юм. Энэ шагнал чинь Засгийн газар олгох юм уу. Засгийн газрын хурлаар энэ шагнал нь орох юм уу. Тэрийг хариулж өгөөч ээ гэж.

П.Ганзориг: Ажлын хэсгээс хариулах уу. Ажлын хэсгийн 5 номер.

Н.Эрдэнэбаяр: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Яг өнөөдөр бол бид нар хууль дээр хүндэт донорыг оруулж өгсөн байгаа. Ер нь тэгэхдээ 2017 оноос эхлээд энэ өгөлтийн тооноос нь хамааруулаад 70-100 удаа өгсөн бол Хүрэл донор, 100-150 удаа өгсөн бол мөнгөн донор, 150-аас дээш 200 хүртэл өгсөн бол алтан донор, 200-аас дээш өгсөн бол Топ донор гэж ийм урамшууллуудыг өгч байгаа. Энэ дээр бас тодорхой тооны хүмүүс сүүлийн 9 жилийн дотор энэ болзлыг хангаж энэ цол тэмдгийг бас гардаж авсан байгаа. Гэхдээ энийг бол яг ЦССҮТ дангаараа бас яг энэ хуульд заасан зохицуулалтын дагуу урамшуулах, алдаршуулах гэдэг үүднээс ингэж олгож явж байгаа. Яг хууль дээр бол тухайлан тусгаж өгөөгүй.

Хүндэт донор гэдэг бол 1962 оноос хойш өгсөн ийм ойлголт байгаа. Анх бол 8 удаа өгөхөд нь өгдөг байсан бол ингээд 20 удаа, дараа нь 35 удаа гээд ингээд нэмэгдээд явж байсан. Энэ түүхэн цаг үе тухайн хүн амын дунд цусаа өгөх мэдлэг хандлагын өөрчлөлтийн байдлууд, тэгээд энэ технологийн дэвшлүүд зөвхөн бүхэл цус биш цусны бүрэлдэхүүн хэсгийг аппаратын тусламжтайгаар авдаг. Энэ орчин үеийн технологиуд нэвтэрсэнтэй холбоотойгоор энэ өгөлтийн тоо олон байх боломжууд бүрдэж байгаатай холбоотой ингэж энэ зүйлүүд явсан. Яг хууль дээрээ бол тухайлан алт, мөнгө, хүрэл донор гэж бас зааж өгөөгүй байгаа. Яг одоогийн төсөл дээр.

П.Ганзориг: Гишүүд асуулт асууж дууслаа.

56.Төслийн 24 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “, мэргэжлийн хяналтын” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 64 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

57.Төслийн 27 дугаар зүйлийн гарчгийн “Цусны донорын үйл ажиллагааны журмыг зөрчигчдөд” гэснийг “Хууль зөрчигчид” гэж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг “Төрийн албаны тухай” гэж, тус тус өөрчилж мөн зүйлийн 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 18 гишүүн дэмжиж, 72 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.1 дэх хэсэг нэмэх:

“28.1.Энэ хуулийн 6.1.6, 8.1.5, 9.4, 13.6-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлтэй холбоотой хэсэг, заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 29 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

59.Төслийн 29 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 18 гишүүн дэмжиж, 72 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн саяын энэ зарчмын зөрүүтэй санал гарч, санал хураалгаснаас бусад зүйл, заалттай холбоотойгоор асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Цусны донорт өгч байгаа, зохион байгуулж байгаа, дэмжиж байгаа байгууллагуудыг Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль гээд. Энэ хуулийг буцаасан шалтгаан нь юу вэ гэхээр дагасан хууль. Төсөв хэлэлцэх үед буюу тэр үеэр хэлэлцүүлье гэдэг байдлаар буцааж байгаа. Ер нь бол энэ нь өөрөө бас энэ хуулийн нэгэн дагах хууль нь дэмжих, энэ үйл ажиллагаанд хандив өргөсөн, тодорхой хэмжээний үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг тодорхой хэмжээгээр орлогын албан татварын хөнгөлөлтөд оруулъя гэдэг байдлаар ийм заалт байсан. Тийм учраас энийг бол тэр аж ахуйн нэгж, байгууллага буюу татварын хууль тогтоомж хэлэлцэх үед марталгүйгээр ажлын хэсгээс тусгайлан дараагийн өргөн барих хуульд оруулах ийм асуудал.

П.Ганзориг: Наадах чинь дараагийн хуулийн асуудал юм байна. Энийгээ дуусгачхаад дараагийн хууль дээр хэлээрэй. Гишүүд асуулт асууж дууслаа.

60.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 18 гишүүн дэмжиж, 72 хувиар санал дэмжигдлээ.

Цусны донорын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Цусны донорын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн хэлэлцүүлгийг эхэлье.

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Таны саналыг сонсчихсон. Ажлын хэсэг хууль санаачлагчид бас Эрдэнэбат гишүүний саяын хэлсэн саналыг сонссон.

Цусны донорын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

2.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 25 гишүүн оролцсоноос 17 гишүүн дэмжиж, 68 хувиар санал дэмжигдлээ.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооныхоо нийт гишүүддээ бас талархал илэрхийлье. Маш өндөр хувийн ирцтэй буюу 83 хувиар хуралдаж бас анхны хэлэлцүүлгийг амжилттай хийлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан гишүүн танилцуулна.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Эрхэм Байнгын хорооны нийт гишүүн, ажлын хэсэг, хууль санаачлагч нарт бас талархал илэрхийлье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ